

4.7 Туршилтын төслүүдийн үнэлгээ

Туршилтын төсөл тус бүрийн хэрэгжилтийн явц байдалд хийсэн эцсийн шатны үнэлгээний үр дүнг доор хураангуйлан үзүүлэв. Оновчтой байдал, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, үр нөлөөлөл, бие даан хөгжих чадвар гэсэн 5 үндсэн үзүүлэлтээс гадна сургамж, зөвлөмж гэсэн үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ өгсөн болно. Дараахь хүснэгтэд 5 үндсэн үзүүлэлтийн гол агуулгыг тоймлон харуулав.

Хүснэгт 4.7.1 Үнэлгээний 5 үзүүлэлтийн гол агуулга

Үнэлгээний үзүүлэлт	Үнэлгээний агуулга
Оновчтой байдал (Relevance)	Төслийн зорилго болон эрхэм зорилго нь хөгжлийн бодлого, чиглэл, төслийн үр шимийг хүртэгчдийн хүсэлт, хэрэгцээнд нийцэж буй эсэхийг магадлаж, үнэлгээ өгнө.
Үр дүнтэй байдал (Effectiveness)	Төслийн зорилгын биелэлтийн төвшин, цаашдын чиг хандлагад үнэлэлт өгнө. Мөн төсөл хэрэгжсэнээр төслийн зорилго үнэхээр хэрэгжих эсэхийг магадлана.
Үр ашигтай байдал (Efficiency)	Хөрөнгө оруулалтын чанар, хэмжээ, цаг хугацаа болон үр дүнгийн уялдаа холбоог судалж, төслөөс нийлүүлсэн хөрөнгө үр ашигтайгаар ашиглагдаж байгаа эсэхийг магадлан үнэлгээ өгнө.
Үр нөлөөлөл (Impact)	Төсөл хэрэгжсэнээр түүний үр шимийг хүртэгчдэд төдийгүй бүс нутгийн нийгмийн амьдралд ямар үр нөлөөлөл үзүүлж буй, цаашид ямар үр нөлөөлөл үзүүлж болох талаар судалж үнэлгээ өгнө. Ингэхдээ төслийн хэрэгжилтээс үзүүлж болох эерэг ба сөрөг үр нөлөөлөлд үнэлгээ өгнө.
Бие даан хөгжих чадвар (Sustainability)	Төслийн зүгээс үзүүлэх дэмжлэг зогссоны дараа үйл ажиллагаа нь цаашид тогтвортой үргэлжлэн явагдаж, тогтвортой үр дүн гарч байх эсэхийг магадлан үнэлгээ өгнө.

4.7.1 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

1. Төслийн тойм
<ul style="list-style-type: none"> * Хамрагдах сумууд: Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сум * Хамрагдах бүлэг: Малчдын бүлэг * Хэрэгжүүлэгч байгууллага: Сумын ЗДТГ, малчдын бүлэг
1-1 Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм.
<p>Мал аж ахуй нь монгол улсын эдийн засгийн гол салбарын нэг бөгөөд бэлчээр уст цэгээс ихээхэн хамааралтай нүүдлийн мал аж ахуй юм. Бэлчээр, усны аль нэг нь байхгүй бол нүүдлийн мал аж ахуй оршин тогтнох нөхцөлгүй бөгөөд өнөө үед тэдгээрийн байршил, ашиглалтын тэнцвэр алдагдсан нь бэлчээрийг зүй зохистой ашиглахад саад болж, ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийн талбай нэмэгдэн, тодорхой худаг, бэлчээрт малын бөөгнөрөл үүсч бэлчээрийн талхдалыг бий болгоход хүргэж байна. Энэхүү судалгааны төсөл нь дээр өгүүлсэн бэлчээр, усны ашиглалтын балансыг сайжруулах асуудлыг чухалчлан авч үзэж байгаа бөгөөд уст цэгийг эзэмших, бэлчээрийн менежментийн тогтолцоог бий болгох, зүй зохистой ашиглах замаар бэлчээрийн талхдалыг багасгах зорилго тавьж байна.</p> <p>Тэрчлэн худгийг урт хугацаагаар тогтвортой ашиглахын тулд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, бэлчээр ашиглалтын асуудалд онцгой анхаарал тавих шаардлагатай. Малчид өнгөрсөн хугацаанд худгийнхаа засвар үйлчилгээний асуудлыг анхаардаггүй, хариуцдаггүй байсан тул худгаа тогтвортой ашиглаж чаддаггүй байлаа. Иймд энэхүү төсөл нь зүгээр нэг худаг гаргаад, засварлаад орхихгүй, малчдын бүлэг бүрт худгийн ашиглалт хамгаалалтын зохион байгуулалтыг бий болгох, төслийн үр шимийг хүртэгч малчдад худагтаа эзэн хүний ёсоор хандах сэтгэл зүйг төлөвшүүлэх, худгийн ашиглалт, хамгаалалтын санг байгуулан ашиглах (Сумын худгийн сан, малчдын бүлгийн сан) зэрэг худгийг тогтвортой ашиглахад чиглэсэн арга замууд, бүс нутгийн бэлчээр, уст цэгийг ашиглалтын мониторингийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бэлчээрийн менежментийн арга технологи, үр чадварыг малчдад эзэмшүүлэх зэрэг асуудлуудыг туршилтын төслийн хүрээнд туршин хэрэгжүүлж байна.</p>

1-2 Хамтын ажиллагааны агуулга

(1) Зорилго

- 1) Төслийн зорилго :
Бэлчээрийн талхдалыг багасгах
- 2) Эрхэм зорилго
Бэлчээрийг зүй зохистойгоор тогтвортой ашиглах

(2) Үр дүн

- 1) Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг малчид хариуцдаг тогтолцоо бий болох
- 2) Бэлчээр ашиглах зорилгоор худгийг сэргээн засварлах, шинээр гаргах
- 3) Бэлчээрийн менежментийн зохистой тогтолцоо бий болох

(3) Хөрөнгө оруулалт, оролцоо(Input)

Японы тал:

Сургалт семинарын хөтлөгч багш нар,Худаг гаргах ажилд ашиглах багаж хэрэгсэл, материал (насос, цахилгаан үүсгүүр зэрэг),Худаг сэргээн засварлах, шинээр гаргах зардал,(14.2 сая япон иен. Үүнд: 12 худгийн сэргээн засварлалт, 5 худаг шинээр барьж байгуулсан ажлын өртөг, барилгын материал, худгийн насос, цахилгаан үүсгүүр зэргийг худалдан авсан үнэ зэрэг орсон),Худгийн ашиглалт, үйлчилгээний сургалт (42,000 иен), бэлчээрийн хэмжилтийн гарын авлага

Дорноговь аймгийн ЗДТГ

Мал аж ахуйн мэргэжилтэн, Худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сургалт (20,000 иен)

Сумуудын ЗДТГ:

Сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, Багийн Засаг дарга, ЗДТГ-ын ХАА хариуцсан түшмэл, төрийн сангийн төлөөлөгч

Малдчын бүлэг:

Малчдын бүлгийн гишүүд,
Худаг сэргээн засварлах / шинээр гаргах ажлын зардлын зарим хэсэг (Уурхайн худаг 500,000 төгрөг, өрөмдмөл худаг 750,000 төгрөг.) ашиглалт, хамгаалалтын зардал

2. Үнэлгээний үр дүн

2-1. Үйл ажиллагааны ололтын шалгуур, нотолгоо

(1) Төслийн зорилго

Ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрт худаг байгуулалтын ажлыг гүйцэтгэснээр ашиглах бэлчээрийн талбай нэмэгдэж, усан хангамж сайжирч, ингэснээр бэлчээрийн даац хэтрэлт тодорхой хэмжээгээр багассан гэж үзэж болох юм. Гэвч туршилтын төсөл эхэлсэнээс хойш хугацаанд зуны улиралд хур тундас багатай, гандуу цаг агаар удаан үргэлжилсний улмаас бүс нутгийн бэлчээр, түүн дотроо худаг орчмын бэлчээрийн байдал ихээхэн муудсан тул одоохондоо тодорхой дүгнэлт хийхэд арай эрт байна. Тэрчлэн малчдын бүлгүүд цаашид худгаа тогтвортой ашиглаж хамгаалан, бэлчээрийн нөөцийн зүй зохистой ашиглалт дээр үндэслэсэн бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж явах нь энэхүү туршилтын төслийн зорилго биелэх гол нөхцөлийн нэг болох юм.

(2) Үр дүн

Үр дүн 1) Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг малчид хариуцдаг тогтолцоо бий болох

Ган гачгийн нөлөөгөөр худгаа төлөвлөсөн ёсоороо ашиглаж чадахгүй байгаа болон бүлгийн гишүүд бүлгээс гарч явж байгаа хүнд нөхцөл байдлын дунд 15 малчны бүлэг зохион байгуулалттай үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна. Моторын эвдэрэл их, засуулахад их хугацаа ордог зэргээс урт хугацаагаар худгаа ашиглаж чадахгүй байдал үүсдэг. Иймд сум бүрт тоног төхөөрөмжийн засварчин бэлдэх асуудлыг сумуудын ЗДТГ болон Дорноговь аймгийн ЗДТГ-тай хамтран шийдвэрлэж, засварчны сургалтыг зохион байгууллаа. Мөн Сумын худгийн сангаас хөрөнгө гарган, сум бүрт ойр зуурын сэлбэгийн нөөц байгуулах асуудлыг шийдэж, малчдын бүлгүүд болон сумуудын ЗДТГ худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудлыг хамтран хариуцах зохион байгуулалтыг бий болгож байна. Гэвч одоогоор энэ зохион байгуулалт бий болж, үр дүнтэй ажиллаж чадахыг дүгнэж хэлэхэд эрт байгаа тул малчдын бүлгүүд худгаа, тогтвортой ашиглаж хамгаалан, сумын ЗДТГ идэвхитэй дэмжин оролцож байх явдал маш чухал юм.

Үр дүн 2) Бэлчээр ашиглах зорилгоор худгийг сэргээн засварлах, шинээр гаргах

3 суманд нийт 17 худгийн ажил хийгдсэнээр энэхүү үр дүнд хүрлээ. Эдгээрийн 15 нь өрөмдмөл худаг бөгөөд 2 уурхайн худагт насос суурьлуулсан болно. Гэвч гадаад нөхцөл байдлын(ган гачиг) улмаас худаг орчмын бэлчээрийн байдал муудаж, худаг орчмын бэлчээрийн ашиглалт хязгаарлагдах тохиолдол байдаг.

Үр дүн 3) Бэлчээрийн менежментийн зохистой тогтолцоо бий болох

Сумын ЗДТГ-ын голлох оролцоотойгоор, малчидтай хамтран бэлчээрийн хялбар хэмжилтийн зохион байгуулалтыг бий болгох, нүүдэл суудалд мониторинг хийх, худаг, уст цэг бүрийг ашиглаж байгаа малын тоо толгойг тогтоох зэрэг бүх төрлийн үйл ажиллагааг нэвтрүүлэн, бэлчээрийн гарц ба ашиглалтын хяналтын тогтолцоог бий болгож, жил бүр бэлчээрийн байдлаас хамааран отор нүүдэл зохион байгуулж, нэг газар малын бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх зэргээр малчид хоорондоо эв зүйгээ олж уламжлалт бэлчээр ашиглалтыг "журам"-ыг зүй зохистой хэрэгжүүлж байна. Сумын ЗДТГ малчид болон бэлчээрийн менежменттэй холбоотой мэдээллийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийж, үүн дээрээ үндэслэн малчидад бэлчээрийн зүй зохистой ашиглалтын заавар, зөвлөмж өгөөд явж чадах найдвар төрж байгаа боловч сумын ЗДТГ-ын ажилтанууд, багийн дарга, малчидад зориулсан сургалтыг үргэлжлүүлэн явуулж байх шаардлагатай.

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой (зүй зохистой) байдал

Хуурай уур амьсгалтай говийн бүсийн мал аж ахуй нь худгаас бүрэн хамаарах тул худгийн тогтвортой ашиглалт, хамгаалалтыг хангах нь мал аж ахуйн өмнө тулгарч буй зорилт юм. Тачирхан бэлчээртэй говийн бүсэд худаг байгуулалтын ажлыг өрнүүлэхийн хамт уст цэгийн орчимд олон мал багширан, бэлчээрийн талхдал үүсгэхээс сэргийлсэн бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд энэхүү төсөл нь үүнд хувь нэмэр оруулах юм.

ХХАА-н талаар төрөөс баримтлах бодлого (2003)-д бэлчээрийг үр ашигтай ашиглахын тулд уст цэгийг сэргээн засварлах, шинээр барих, засвар үйлчилгээний тогтолцоог бий болгоход нэн тэргүүний ач холбогдол өгч байна. улмаар "Малчдад худаг ашиглах эрхийг нь олгож, үүний хариуд малчид засвар үйлчилгээний зардлыг хариуцна" гэж шинэ "Усны хууль" (2004 оны 7 сар)-д заасны дагуу 2005 оны 7 сард батлагдсан "Инженерийн худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-д 1) Хариуцах зардал нь барилгын ажлын зардлын тодорхой хувь байх (манай төслийн хувьд хариуцах зардал нь тодорхой хэмжээнд байхаар шийдвэрлэсэн), 2) Барилгын ажил эхлэхээс өмнө хариуцах зардлаа төлсөн байх (манай төслийн хувьд барилгын ажлын дараа хэсэгчлэн төлөхөөр байгаа) нөхцөлтэй байхаар тусгасан байна. Энэхүү журамд заасны дагуу малчдын хариуцах зардлын хэмжээнд өөрчлөлт (багасгах) оруулж, төрөөс баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулсан. Төлбөрийн арга хэлбэрийн тухайд бол үг төслийн хувьд, урьд баримталж ирсэн хэсэгчлэн төлөх хэлбэрийг хэвээр нь байлгах тухай болон засвар өөрчлөлт оруулсан нийт хариуцах зардлын дүнгийн талаар ХХААЯ, Дорноговь аймгийн захиргаа, төсөлд хамрагдсан сумдуудын ЗДТГ-тай ярилцаж төслийн оновчтой байдлыг хангахаар тохиролцов.

Худаг орчмын бэлчээр ашиглалтын журам боловсруулах тухайд, бэлчээр нь уламжлалт арга хэлбэрээр ашиглагдаж байгаа, нөгөө талаар малчид албажуулсан журам боловсруулах шаардлагагүй гэж үзсээр байна. Үүнээс шалтгаалан журам боловсруулах асуудал хүндрэлтэй учирч байна. Иймд сумын ЗДТГ голлох үүрэгтэй оролцож малчид болон орон нутгийн засаг захиргаа бэлчээрийн байдлын мэдээллийг хамтран ашиглах хэлбэрийн бэлчээрийн менежментийн тогтолцоог бий болгож, зүй зохистой (оновчтой), амьдралд ойрхон байх үзүүлэлтүүдийг хангахаар боллоо. Энэхүү бэлчээрийн мэдээллийг хамтран ашиглах зохион байгуулалт бий болж, үр дүнгээ үзүүлэхэд тодорхой хугацаа шаардагдана.

(2) Үр дүнтэй байдал

Төслийн хүрээнд шинээр 5, сэргээн засварласан 12, нийт 17 газарт худгийн ажил хийгдсэнээр ("Үр дүн 2" буюу "Бэлчээр ашиглах зорилгоор худгийг сэргээн засварлах, шинээр гаргах" ажлын биелэлт) ашиглах боломжтой бэлчээрийн талбай нэмэгдэж, төслийн зорилго тодорхой хэмжээнд биелээд байна. Энэхүү үр дүнг баталгаажуулахад малчдын бүх бүлгүүд худгийнхаа ашиглалт хамгаалалтыг тогтвортой үргэлжлүүлж явах "Үр дүн-1" буюу худгийн ашиглалт, засвар үйлчилгээг малчид хариуцдаг бүтэц тогтолцоо бүрэлдэн тогтох явдал зайлшгүй шаардлагатай юм. Мөн, тэдний үйл ажиллагааг хянаж зохицуулах сумын ЗДТГ-уудын үүрэг роль ч төслийн зорилгын биелэлтэд чухал үүрэгтэй.

Бүх малчдын бүлэг бүлгийн сан байгуулахын зорилго, ач холбогдол, Сумын худгийн санд хөрөнгө оруулалтын зардалыг буцаан төлөхийн утга учрыг сайтар ойлгож байгаа. Тэрчлэн сумын худгийн сангийн дэмжлэгээр сэлбэг хэрэгсэл худалдан авсан малчид байгаагаас үзэхэд үр дүнтэй ашиглагдаж байна гэж дүгнэж болно.

"Үр дүн 3"-тай холбоотойгоор бэлчээрийн хялбар хэмжилтийн зохион байгуулалтыг бий болгох, отор, нүүдлийн мониторинг хийх, ашигладаг уст цэгийн судалгаа, худаг уст цэг бүрт байгаа малын тоог тогтоох зэрэг олон төрлийн ажлыг нэвтрүүлснээр сумын ЗДТГ-ын удирдлага зохион байгуулалтын доор бэлчээрийн төлөв байдлыг иж бүрнээр тодорхойлох бүтэц зохион байгуулалтыг бий болголоо.

(3) Үр ашигтай байдал

Шинээр 5, сэргээн засварласан 12, нийт 17 газарт худгийн ажил хийгдсэн болно. Эдгээр 17 худгаас 15 худгийг нь малчдын бүлгүүд зохион байгуулалттай ашиглаж эхэлсэн бөгөөд одоо ч үргэлжлүүлэн ашиглаж байна. Төлөвлөсөн үр дүнд хүрэх, төслийн зорилгын биелэлтийг хангахад худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажил ихээхэн хувь нэмэр оруулсан болно.

Мөн, хүчин чадал, чанар, сэлбэг хэрэгслийн олдоцын байдлыг бодолцон худгийн байгууламжид тухайн үедээ хамгийн тохиромжтой тоног төхөөрөмжүүдийг олж нийлүүлсэн гэж үзэж байна. Гэхдээ худагт тавьсан моторууд эвдэрч, гэмтэх нь их байгаа бөгөөд 15 бүлгийн 10-ынх нь моторт эвдрэл гарсан байна. (Эвдэрлийн шалтгаан нь малчидын буруу ашиглалт болон моторын чанарын аль алинд нь байна гэж үзэж байна.) Их хэмжээгээр гарч байгаа тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлийн эсрэг сум, аймгийн ЗДТГ техникийн арга хэмжээ авах чадвар, зохион байгуулалттай болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ оны 9-р сард тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтын зохион байгуулалтын асуудлыг судалгааны баг, холбогдох зардлыг Дорноговь аймгийн ЗДТГ хариуцсан болно.

Бэлчээрийн менежментийн сургалтаар малчдад хэмжилтийн багаж хэрэгсэл (30 иж бүрдэл) олгон, "Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн хэмжилт хийх гарын авлага" боловсруулж, сумдад тус бүр 40 хувийг тараан, хэмжилтийн сургалт явуулав. Ингэснээр бэлчээрийн байдлыг нийтлэг, бодит тоон үзүүлэлтээр хэмжиж тодорхойлох арга чадварыг малчдад олгосон гэж үзэж байна. Сумуудын ЗДТГ-ын ХАА-н түшмэлүүдэд зориулан бэлчээрийн хэмжилт хийх арга зүйгээс гадна бэлчээрийн даац тодорхойлох талаар сургалт явуулав.

(4) Үр нөлөөлөл

Инженерийн худгийг шинээр гаргаж, сэргээн засварласнаар ашиглалтгүй бэлчээрийг ашиглах боломжтой болсон, хөдөлмөр хөнгөвчлөгдсөн, мал услах цаг богиносж, бэлчээх цаг уртасаж, үүний үр дүнд мал сайтар тарга хүч авах болсон зэрэг эерэг үр нөлөөлөл бий болсныг малчид мэдэрч байгаа бөгөөд нийт малчдын бүлгийн 80% нь энэхүү төслийн хэрэгжилтэнд сэтгэл ханамжтай байна гэсэн хариулт өгч байлаа. Тэрчлэн төсөлд хамрагдсан малчид төдийгүй сумын бусад малчид, зэргэлдээ сумаас отор хийж ирсэн малчид хүртэл төслөөр засварласан, шинээр гаргасан худгуудыг ашиглаж байгаа нь төсөл өргөн хүрээнд үр нөлөөлөл үзүүлж буйг харуулж байна. Нөгөө талаар ган гачигаас болоод худаг орчмын бэлчээр муудсан тул ашиглая гэвч ашиглаж чадахгүй, үр дүнг нь мэдэрч чадахгүй малчид ч байна.

Тэрчлэн 2004 оын 12 сард Дорноговь аймгийн төв Сайншанд хотод зохион байгуулсан "Санал солилцох уулзалтын үер" малчид болон төр, захиргааны байгууллагууд харилцан санал солилцож, малчдын хариуцах зардалын талаархи ойлголтоо гүнзгийрүүлсэн юм. Энэхүү төслийн үр үн гарахад "Санал солилцох уулзалт" ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн болно.

(5) Бие дааж хөгжих чадвар

Энэхүү төслийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд Сумын ЗДТГ Сумын худгийн санг зүй зохистой ашиглах, малчид худгийн санд хөрөнгө оруулалтын зардалыг буцаан төлөх, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох, малчдын бүлгүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах явдал маш чухал ач холбогдолтой

Төслийн хэрэгжилтийн явцад Улаанбадрах, Хөвсгөл сумуудын Засаг дарга нар солигдож, ажлаа сайтар хүлээлцээгүйн улмаас шинэ дарга нар сумын худгийн сангийн ашиглалт болон малчдаас санд буцаан төлөх төлбөрийн талаар тодорхой ойлголтгүй байсны дээр малчдын зүгээс ч үл итгэх, эргэлзэх хандлага ажиглагдан, худгийн санд хийх төлбөр зогсонги байдалд орсон нөхцөл байдал үүссэн болно. Цаашид дахин ийм байдал орохгүйн тулд сумын ЗДТГ-ын ажил төрлийн залгамж чанарыг хангах, сумын худгийн сангийн үйл ажиллагааг журмын дагуу ил тод, нээлттэй явуулах нь төслийн бие даан үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сумын худгийн сан нь тухайн сумын нутагт худаг, усны асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд худгийн тоног төхөөрөмж худалдан авахад зээл олгох, сумын ЗДТГ-ын хяналтанд байдаг сэлбэг хэрэгслийн нөөцийг бэлдэх зэрэгт ашиглагдаж байна. Сангийн хөрөнгийн эх үүсвэр нь төслийн хүрээнд шинээр гаргасан, сэргээн засварласан худгийг ашиглах малчдын бүлгүүдээс буцаан төлсөн хөрөнгө оруулалтын зардалаас бүрдсэн бөгөөд малчид холбогдох зардалаа буцаан төлж явах тохиолдолд л сан оршин тогтнох боломжтой юм. Уурхайн худаг ашиглаж буй малчдын бүлгүүд 500,000 төгрөг, ерөмдмөл худаг ашиглаж байгаа малчдын бүлгүүд 750,000 төгрөгийг 3 жилийн хугацаанд (2006 оны 12 хүртэл) төлөх үүрэг хүлээсэн байгаа. 2005 оны 11 сарын байдлаар Улаанбадрах, Хөвсгөл сумуудын Худгийн сангийн бүрдэлт тааруу, цаашид бие даан хөгжөөд явах найдвар тэрүүлхээргүй дүр зураг харагдаж байна. Харин Эрдэнэ сумын Худгийн сангийн бүрдэлт сайн байна.

3 сумын Худгийн сангийн бүрдэлтийн байдал (2005.11.30)

	Эрдэнэ	Улаанбадрах	Хөвсгөл
Малчдын бүлгүүдээс худгийн санд хийсэн төлбөрийн дүн(төг)	1,910,000*	1,060,500	993,435
Сангийн бүрдэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл (%). 2005 оны 11 сарын байдлаар	95	43	55
Малчдын бүлгийн тоо	5	6	4

*Эрдэнэ сумын ЗДТГ –ын хяналтанд байдаг худгийн хөрөнгө оруулалтын зардлыг сумын ЗДТГ төлсөн бөгөөд үүнийг оруулан тооцвол нийт дүн нь 2,120,000 төгрөг болно.

Дорноговь аймгийн ЗДТГ-ын оролцоотойгоор сумуудын худгийн тоног төхөөрөмжийн засварчин бэлтгэх сургалт зохион байгуулж, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зохион байгуулалтыг бий болгох ажлыг эхэллээ. Сумын ЗДТГ-ын хяналтан доор ашиглах сэлбэг хэрэгслийг удахгүй хүлээж авах бөгөөд худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зохион байгуулалт ерөнхийдээ бий болж байна.

Өнөө хүртэл худаг ашиглаж ирсэн 15 малчны бүлэг нь цаашид ч бүлгийн зохион байгуулалтаар тогтвортой үйл ажиллагаа явуулах магадлал өндөр байна. 1 өрхөөс бүрдсэн 2 бүлэг байгаа бөгөөд өрхийн тоо цөөхний улмаас хөрөнгө оруулалтын зардалыг хоёрхон өрхөөрөө буцаан төлөхөд хүндрэл учирч байгаа боловч тодорхой үр дүн, үр ашгийг нь мэдэрч байгаа тул цаашид ч энэ маягаараа худгаа ашиглаад явахыг зорьж байна.

Дүгнээд хэлэхэд өнөөгийн шатанд ч цаашид бие даагаад явах болов уу гэсэн найдлага төрж байгаа боловч дээр хэлсэнчлэн, сумын санд хөрөнгө оруулалтын зардалыг буцаан төлөх, засвар үйлчилгээний зохион байгуулалтыг бодитойгоор бий болгох, сумын засварчны үр чадварыг дээшлүүлэх зэрэг нь төслийн бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2-3. Үр дүн гарахад нөлөөлсөн хүчин зүйл

(1) Төслийн агуулгатай холбоотой хүчин зүйл

Худаг ашиглах малчдын бүлгээр зардлын нэг хэсгийг хариуцуулснаар 15 бүлгийн малчид өөрсдийн худгаа эзний ёсоор үргэлжлүүлэн ашиглан, хамгаалж, тодорхой үр дүн гарч байна.

(2) Төслийн хэрэгжилттэй холбоотой хүчин зүйл

Холбоо, зам харилцаа муутай хөдөө орон нутагт тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг хийхэд сумын ЗДТГ-ын оролцоо туйлын их ач холбогдолтой юм. Сумын ЗДТГ Худгийн сангийн бүрдүүлэлтээр дамжуулан худгийн байдалд анхаарал тавьж, малчидтай дотночлон ярилцаж, худгуудын ашиглалт хамгаалалтын талаар хүлээсэн хариуцлагаа ухамсарлах болсон нь төсөл цаашид бие даан үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан болно.

Сайншандад зохион байгуулсан "Санал солилцох уулзалтын" явцад малчдын бүлэг болон төр засгийн төлөөлөгчид нүүр тулан ярилцаж, төслийн зорилго, чиглэлийн талаархи малчдын ойлголтыг гүнзгийрүүлэв. Ингэснээр худгийн санд хөрөнгө оруулалтын зардалыг буцаан төлөхийн утга учрыг малчид сайтар ойлгож, төлбөрийн гүйцэтгэл сайжирсан нь төслийн бие даан үргэлжлэх нөхцөлийг хангасан нэг хүчин зүйл болсон гэж үзэж байна.

Тэрчлэн эцсийн үнэлгээг оролцуулан нийт 3 удаа сургалт (workshop) явуулах үеэр малчдын бүлгийн гишүүд цуглан худгийн ашиглалт, хамгаалалтын талаар санал, мэдээлэл солилцон, зохион байгуулалттай бүлгийн үйл ажиллагаа болон данс бүртгэлийн талаар тодорхой мэдлэг олж авч байлаа. Малчдыг бүлгийн зохион байгуулалтанд оруулан, сургалт (workshop)-ыг удаа дараа явуулж байсан нь төслийн бие даан үргэлжлэх нөхцөлийг

хангах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зохион байгуулалтыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

2-4. Асуудал бэрхшээл болон асуудал бэрхшээлийг үүсгэсэн хүчин зүйл

-Эвдэрсэн тоног төхөөрөмжийг засуулахаар Улаанбаатарт байдаг гүйцэтгэгч рүү явуулаад 2,5-6 сарын хугацаа өнгөрөхөд хангалттай арга хэмжээ авч өгөхгүй тохиолдол гарч байлаа. Гүйцэтгэгч компани нь худаг ашиглагчдын отор, нүүдэл, малчдын зүгээс сумын худгийн санд буцаан хийх төлбөр, худаг ашиглалтанд саад учруулахгүй хэмжээнд хангалттай арга хэмжээ авах шаардлагатай байсан боловч малчдын хувьд тэр хол байгаа гүйцэтгэгчийг хөдөлгөх хэлэлцээрийн үр чадвар, арга хэрэгсэл дутагдаж байлаа.

-Худгийн мотор их эвдэрч байлаа. Үүний шалтгаан нь малчдын ашиглалтын чадвар, байгууламжийн бүтэц, зохион байгуулалтаас гадна моторын чанарт байгаа болов уу гэж үзэж байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд Сумын худгийн сангаас хөрөнгө гарган сумын ЗДТГ-т сэлбэг хэрэгслийн нөөц байгуулан, тоног төхөөрөмжийн засварчны сургалтыг зохион байгуулав. Ингэснээр тодорхой хэмжээнд засвар үйлчилгээ хийх зохион байгуулалтыг бий болгосон боловч засварчны үр чадвар хангалттай хэмжээнд хүрээгүй байгаа болно.

-Зарим сумын удирдлага, түшмэлүүд солигдох үед ажил төрлөө сайтар хүлээлцээгүйгээс сумын ЗДТГ нэг хэсэг хугацаанд Сумын худгийн сангийн байдлыг сайтар ойлгохгүй байлаа.

2-5. Дүгнэлт

"Бэлчээрийн талхдалыг арилгах" гэсэн төслийн зорилго худаг байгуулалтын ажлын үр дүнд тодорхой хэмжээгээр биелсэн боловч үүнийг бодит зүйл болгохын тулд цаашид худгийн ашиглалт, хамгаалалтыг тогтворжуулах, шинээр худаг гаргах зайлшгүй шаардлагатай юм. Одоогийн байдлаар бүх бүлгүүд худгийнхаа ашиглалт хамгаалалтыг үргэлжлүүлээд явж байна. Цаашид худгийн ашиглалт хамгаалалтыг үргэлжлүүлэн явахад малчдын бүлгүүд сумын санд хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн төлөх, судалгааны төсөл дуусах үеэр бий болгосон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зохион байгуулалтыг ажилуулах зэрэг зорилтыг шийдвэрлэх шаардлагатай юм.

Бэлчээрийн талхдалыг арилгах гэдэг нь зүгээр нэг уст цэг байгуулах төдийгээр шийдэхэд хүндрэлтэй асуудал тул бэлчээрийн менежментийн иж бүрэн тогтолцоог бий болгох замаар шийдвэрлэх шаардлагатай. Малын тоо толгой, малчдын нүүдэл суудлын бүртгэл, уст цэгийн судалгаа, бэлчээрийн даацын тэмдэглэл зэрэг ажлыг сумын ЗДТГ удирдлага, зохион байгуулалтын доор гүйцэтгэдэг" бэлчээрийн менежментийн бүтэц зохион байгуулалтыг" бий болгох асуудлыг туршиж үзлээ. Гэвч эдгээр ажлын хүрээнд олж авсан мэдлэг, туршлага, үр чадварыг байнгын сургалтаар улам сайжруулж байх шаардлагатай. Малчид болон сумын ЗДТГ одоогийн байдлаар анхан шатны ойлголтыг л авсан бөгөөд, сургалын хүрээнд олгосон арга барил, мэдлэг туршлагыг төгс эзэмшсэн гэж хэлж болохгүй юм.

2-6. Зөвлөмж

- Инженерийн худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-д заасанчлан худгийн ажлын зардлын тодорхой хэсгийг уг худгийг ашиглах малчид хариуцаар болж байгаа билээ. Гэхдээ 1) Ажлын зардал нь худгийн гүнээс хамааран худаг бүр дээр өөр өөр гарч болохоос гадна худгийн чадавхи нь гарсан зардлаа зөвтгөх хэмжээнд хүрэхгүй байх магадлалтай тул малчдын дунд тэгш бус байдлыг үүсгэнэ. 2) Худгийн ажлын зардлыг тогтоох хүртэл малчид өөрсдийн хариуцах ёстой зардлын хэмжээг мэдэхгүй. 3) Ажлын процедур, хариуцах зардалыг тооцоолж гаргахад төвөгтэй, чирэгдэл ихтэй байж болзошгүй тул худаг ашиглагчийн хариуцах зардалыг энэхүү судалгааны төслийн хүрээнд туршиж үзсэнтэй адилаар худгийн төрөл тус бүрээр нь ижил хэмжээгээр тогтоохыг зөвлөө.

- Худгийн ашиглалт, хамгаалалтыг малчид хариуцах ёстой боловч холбоо, тээвэр, харилцаа муутай хөдөө газрын малчдад бүх юмыг даатгаад орхих нь учир дутагдалтай тул сумын ЗДТГ сэлбэг хэрэгсэл олж нийлүүлэх, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудлыг нь ярьж өгөх тал дээр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Иймд сумын ЗДТГ ийм дэмжлэгийн арга хэмжээнд зарцуулах багаахан хөрөнгийн эх үүсвэртэй байх хэрэгтэй бөгөөд худаг байгуулалтын ажлыг эхлэхтэй хамт Сумын худгийн санг байгуулан ашиглаж байхыг зөвлөө.

- Тоног төхөөрөмжийн ашиглалт хамгаалалтыг хэвийн байлгахын тулд эвдрэл гэмтэл гарахаас өмнө зааварчилга, зөвлөмж өгдөг зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай байна. Мөн өдөр тутам зөвөрлөж ашигладаг худгийн мотор эвдэрсэн үед яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй болдог. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогоор тодорхой үр дүн нь хараахан гараагүй байгаа боловч судалгааны төслийн сүүлчийн үе шатанд

хэрэгжүүлсэн сум бүрт худгийн тоног төхөөрөмжийн засварчныг бэлдэх асуудал нэлээд оновчтой санаа байж болох тул хангалттай хугацаанд сургаж, дэмжих зохион байгуулалтыг бий болгосны үндсэн дээр худгийн ажил суманд эхлэх үед үүнийг нэгэн зэрэг нэвтрүүлэхийг зөвлөө.

- Бэлчээр ашиглалтын гэрээнд малчид ойр хавийн бэлчээрийн ургацын байдлыг хэмжин, тэмдэглэл хийж, сумын ЗДТГ-т мэдэгдэж байхыг үүрэг болгон оруулахыг зөвлөө
- Тэрчлэн энэ удаагийн туршилтын төслийн хүрээнд гаргасан худгууд сумуудын хүссэн тоо, хэмжээнд хүрсэнгүй. Худгийг орон нутгийн нийт бэлчээрийн хэмжээнд сайтар баланстайгаар гаргахгүй бол туршилтын төслөөр гаргасан цөөхөн хэдэн худагт ихээхэн ачаалал ирнэ. Иймд ойрын хугацаанд орон нутгийг хамарсан худаг байгуулалтын ажлыг ернүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
- Сумуудын ЗДТГ ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрт худаг гаргахыг чухалчлан үзэж байсан бол малчид өөрсдийн нүүдэл хийж, ашиглаж ирсэн бэлчээрийн хүрээнд худаг гаргуулахыг хүсэх хандлага ажиглагдлаа. Бэлчээр ашиглалтын боломжийг нэмэгдүүлэх, ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрийг эзэмшихийн тулд зөвхөн малчдын хүссэн газар худаг гаргах биш, орон нутгийн хэмжээнд үр бүтээлтэй ашиглаж болох "Сумын мэдлийн худгийг" байгуулах асуудлыг сумуудын ЗДТГ судалж үзэх ёстой. Ирээдүйд ийм ажилд "Сумын худгийн сангийн хөрөнгийг" үр дүнтэй ашиглах боломжийг ч сумуудын ЗДТГ судалж үзэх шаардлагатай гэж үзэж байна.

2-7. Суртамж

- Малчдаар зардлын нэг хэсгийг хариуцуулах болсноор малчдын бүлгийн гишүүдэд худагтаа эзэн хүний ёсоор хандах сэтгэл зүй, хариуцлагыг ухамсарлуулж, худгийн ашиглалт хамгаалалтын тогвортой байдлыг дээшлүүлсэн гэж дүгнэж байна
- Сумын ЗДТГ малчдаас Сумын худгийн санд цугларсан хөрөнгийг туйлын зөв зохистой зарцуулж, сангийн үйл ажиллагааг журамд нийцүүлэн ил тод, нээлттэй явуулах шаардлага хурцаар тавигдаж байна.
- "Иргэдийн оролцооны хэлбэртэй" төсөл нь орон нутгийн амьдралыг идэвхижүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.
- Худгийн засвар үйлчилгээний ажлыг эцсийн дүндээ аймагт ганцхан байдаг худаг, усны мэргэжлийн компани хариуцаж таарах тул худгийн ажил болон тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн тендерт орон нутгийн гүйцэтгэгчийг заавал оролцуулж байх шаардлагатай юм. Тэрчлэн орон нутгийн гүйцэтгэгч тендерт ялж чадахгүй байсан ч засвар үйлчилгээний ажилд идэвхтэй оролцдог, хамтран ажилладаг байх талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.
- Худгийг тогтвортой ашиглаж явахын тулд ашиглагч нь ашиглалтын эхний үед худгийг хүч чадлынх нь бүрэн хэмжээгээр ашиглахын давуу талыг мэдрэх ёстой. Гэвч ашиглаж сураагүйгээс эхний үед эвдрэл, гэмтэл их гардаг. Иймд тоног төхөөрөмжийн тендерийн нөхцөлд баталгаат хугацааг нь зааж өгөхийн хамт эхний хэдэн жилийн засвар үйлчилгээнийх нь зардлыг оруулан тооцох хэлбэрийн тендер явуулах нь хүсүүштэй юм.
- Худгийн ашиглалт, хамгаалалтыг малчид хариуцах ёстой боловч холбоо, тээвэр, харилцаа муутай хөдөө газрын малчдад бүх юмыг даатгаад орхивол сэлбэг хэрэгсэл олж авах, засвар үйлчилгээний хэлцэл хийх тал дээр нэлээн хүндрэл учрах тул орон нутгийн засаг захиргаа тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлж явах шаардлагатай юм.
- Малчид эвдэрсэн мотороо өөрсдөө Улаанбаатарт засварт аваачиж өгсөн тохиолдол 1 л гарсан бөгөөд ер нь энэ асуудал их хүндрэлтэй байдаг. Иймд техникийн үзүүлэлтийн хувьд арай дутуу ч орон нутагт арга хэмжээ авчихаж болохоор тоног төхөөрөмжийг сонгох юмуу орон нутагт засвар үйлчилгээ хийх чадвартай хүнийг сургаж бэлтгэх шаардлагатай.
- Төслөөр нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо цөөхөн байх тохиолдолд тэдгээрийн засвар үйлчилгээний асуудлыг орон нутгийн хувийн компани нэг их сонирхогдоггүй. Мөн бусад компани болон хувь хүмүүс сэлбэг хэрэгсэл нийлүүлэх бизнес хийж байдлыг сайжруулах магадлал тун бага тул орон нутагт ашиглах тоног төхөөрөмжийн төрлийг цөөхөн болгож, аль болох нэг төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэхийг хичээх хэрэгтэй.
- Төслөөр гаргасан худгийн ашиглалтыг тойрсон малчдын маргаанаас зайлсхийхийн тулд сумуудын ЗДТГ инженерийн худгийг төлбөртэй ашиглах ёстой гэсэн санааг эхнээс нь ойр хавийн малчдад ойлгуулж, тодорхой үнэ тарифийг тогтоож, нийтэд мэдэгдэх нь чухал юм.

- Худгийг ашиглаж эхлэхээс өмнө цаашид худгийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийхэд зарцуулагдах малчдын бүлгийн дотоодын санг бодитоогоор байгуулсан байх нь зүйтэй юм.

2-8. Дагалдах ажил

- 3 сумын худгийн сангийн ашиглалтын байдал, малчдын бүлгүүдээс хөрөнгө оруулалтын зардлыг буцаан төлж байгаа байдалд Аймгийн ЗДТГ-аас цаашид үргэлжлүүлэн мониторинг хийж явах нь чухал юм.

- Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийн хувьд ч сумын засварчны ур чадвар хүрэхгүй тохиолдолд худаг усны мэргэжлийн байгуулгын тусламж дэмжлэг шаардагдах бөгөөд энэ ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтыг аймгийн ЗДТГ онцгой анхааран зохицуулах шаардлагатай юм.

- Малчдын бэлчээрийн хэмжилтийн үзүүлэлтүүдийг нэгтгэн бэлчээрийн даацыг тооцоолох сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд мониторинг хийхийн хамт Аймгийн Ус цаг уурын газар тэр тооцоог хянаж, өргөн хүрээнд үр бүтээлтэй ашиглах бүтэц зохион байгуулалтыг бий болгох нь чухал юм. Тэрчлэн сумын ЗДТГ-аас явуулах бэлчээрийн даацтай холбоотой бусад мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг бүх төрлийн судалгааг Аймгийн ЗДТГ дэмжиж байх нь зүйтэй юм.

4.7.2 “Малжуулах сан” төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

1. Төслийн тойм

* Хамрагдсан нутаг : Эрдэнэ сум

* Хамрагдсан бүлэг : Эрдэнэ сумын ЗДТГ

* Хэрэгжүүлэгч байгуулга: Эрдэнэ сумын ЗДТГ

1-1. Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм

Зудаар малаа алдсан малчид судалгаанд хамрагдсан бүс нутгаар хязгаарлагдахгүй Монголын бүх суманд бий. Өрхийн гишүүдийн хэрэглээг элбэг хангахуйц тодорхой хэмжээний малтай байхгүй бол хэрэглээ нь малын өсөлтөөс нь даван гарсанаар мал нь жилээс жилд цөөрөх хандлагатай болдог. Үүний шалтгаан нь мал маллагааны арга туршлага, хувь хүний амьдралдаа хандах хандлага зэргээс гадна ихэнх тохиолдолд зудаар ихээхэн хэмжээний малаа алдсаны дээр олон ам бүлтэй байдаг оршдог байна. Ийм малчид бие даан амьдралаа авч явахын тулд мал маллагааны арга туршлага, ур чадвараа дээшлүүлэн малаа тодорхой тоо толгойноос дээш гарган өсгөх шаардлагатай. Ингэснээр бүх малаа хорогдуулж ядуучуудын эгнээнд шилжихээс сэргийлж чадна. Тэрчлэн малчдад зээлээр олгох малын тодорхой хувь нь шилмэл омгийн мал байгаа тул сумын хэмжээнд малын чанар сайжрах, шилмэл омгийн мал үржихэд хувь нэмэр болно гэж найдаж байна. Ийнхүү энэ төслийн хүрээнд “Малжуулах сан” бодит амьдрал дээр ажиллах боломжтой эсэхийг магадлан тогтоож, цаашид анхаарах, сайжруулах зүйлүүдийг тодорхойлж чадах юм.

1-2 Хамтын ажиллагааны агуулга

(1) Зорилго

1) Төслийн зорилго :
Сумын ЗДТГ “Малжуулах санг” байгуулан ажиллуулах

2) Эрхэм зорилго

Мал аж ахуйн эрүүл, бие даасан тогтолцоог бүрдүүлэхийн хамт цөөн тооны малтай малчдын амьдрал аж ахуйг сайжруулах
Мал сүргийн чанар, бүтэц сумын хэмжээнд сайжрах

(2) Үр дүн

- 1) Малжуулах сангийн удирдлага, хяналтын тогтолцоо бий болох
- 2) Зээл авах малчдыг дэмжих тогтолцоо бий болох
- 3) Малжуулах санг зүй зохистойгоор удирдан зарцуулдаг болох

(3) Хөрөнгө оруулалт, оролцоо (нөлөөлөл)

Японы тал:

Сангийн хөрөнгийн эх үүсвэр болох мал худалдан авах ажлыг санхүүжүүлэх (сайн үүлдэр угсааны малыг оролцуулан) (600 толгой малын үнэ: 2,060,000 иен)

Сумын ЗДТГ

Сумын Засаг дарга, ХАА-н түшмэл, багийн засаг дарга, малжуулах сангийн үйл ажиллагааг хариуцах хүн сангийн үйл ажиллагаанд шаардагдах зардал

Малчдын бүлэг

Дэмжлэг үзүүлэх малчид (Батлан даагч)

2. Үнэлгээний үр дүн

2-1. Үйл ажиллагаа, олсон амжилтыг магадлах

(1) Төслийн зорилго

Сумын ЗДТГ-аас сангийн үйл ажиллагааг идэвхитэй удирдан зохион байгуулж эхний жилийн зээлээс буцаан төлөгдсөн малаас үргэлжлүүлэн 2 дахь жилийн зээлийг олгосоноос үзэхэд Малжуулах сангийн эхний шатны үйл ажиллагаа амжилттай явагдсан гэж дүгнэж болно. Цаашид сумын ЗДТГ улам бүр туршлагажиж, хөрөнгө оруулалтын ажлыг үргэлжлүүлэн явуулж чадвал төслийн зорилго биелэгдэх магадлал өндөр байна.

(2) Үр дүн

Үр дүн 1) Малжуулах сангийн удирдлага, хяналтын тогтолцоо бий болох

Малжуулах сангийн ашиглалтын журам боловсруулагдсан бөгөөд сангийн үйл ажиллагаа хэрэгжиж эхлээд байна. Сангийн үйл ажиллагааг сумын засаг дарга, ХАА-н түшмэл, төрийн сангийн төлөөлөгч нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй «Малжуулах сангийн төлөөлөн удирдах зөвлөл» удирдан зохион байгуулж байна.

Үр дүн 2) Зээл авах малчдыг дэмжих тогтолцоо бий болох

Зээлийн гэрээ байгуулагдсанаар төсөлд хамрагдсан нийт малчид батлан даагч (дэмжлэг үзүүлэх малчид) -тай болсон. Мөн сумын ЗДТГ-аас улиралд 1 удаа, багийн дарга нар сард 1 удаа тэднийг эргэж, мониторинг хийж байна.

Үр дүн 3) Малжуулах санг зүй зохистойгоор удирдан зарцуулдаг болох

Эхний жилийн буцаан төлөлт төлөвлөсний дагуу явагдсан. Судалгааны баг мониторингоо үргэлжлүүлэн хийж явна. Сумын ЗДТГ мөн адил "Малжуулах сангийн төлөөлөн удирдах зөвлөл"-өөр дамжуулан төсөлд хамрагдсан малчдын ажилд мониторинг хийх ажлаа үргэлжлүүлнэ.

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой (зүй зохистой) байдал

Малчид тодорхой хэмжээний малтай байхгүй бол өрхийн хэрэглээ нь малынх нь өсөлтөөс давж мал нь жилээс жилд цөөрөх хандлагатай болдог. Ган, зудын уршгаар малаа хорогдуулсан малчид амьдралаа бие даан авч явахын тулд мал маллагааны арга туршлага, үр чадвараа дээшлүүлэн, малынхаа тоо толгойг тодорхой хэмжээнээс дээш гаргаж өсгөх шаардлагатай.

Тус бүс нутагт дунджаар нэг өрхөд 100 орчим мал ногдож байгаа нь бие даан амьжиргаа, аж ахуйгаа эрхлэн явуулахад хүрэлцэхүйц гэж тооцож буй 200 толгойд хүрэхгүй юм. Энэ байдлаас гарахад "Малжуулах сан" нь бодитоор үр дүнгээ өгөх нэгэн хэрэгсэл болоод зогсохгүй ийм төрлийн сан байгуулж ажиллуулах хэрэгцээ шаардлага ч өндөр, Дэлхийн банк зэрэг байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ч малжуулах үйл ажиллагаа явуулдаг сангууд байгуулагдан ажиллаж ирсэн байна. Мөн Монгол улсын "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр" -т (2003 он) малжуулах сан, малын даатгал, малын тэжээл бэлтгэл зэргийг ядуурлыг бууруулах арга хэрэгсэл гэж тодорхойлсон байдаг. Эдгээр нь уг төслийг хэрэгжүүлэх сонголт зүй зохистой, оновчтой болсныг гэрчилж байна.

Түүнчлэн "Хүнс, Хөдөө аж ахуйн талаар төрөөс барих бодлого" (2003 он)-д сайн үүлдэр, угсааны малыг малжуулах сангийн үйл ажиллагаанд түлхүү сонгон ашиглахыг онцлон тэмдэглэсэн байдгаас үзэхэд энэ төслийн хүрээнд зээлээр олгох сангийн малд орон нутгийн шилмэл омгийн мал оролцуулсан нь мөн оновчтой, зөв шийдэл болсныг нотолж байна. Төсөл хэрэгжүүлж буй Дорноговь аймаг шилмэл омгийн малын тоо толгойг өсгөхөд ихээхэн анхаарч, аймгийн ХАА-н Газраас янз бүрийн арга хэмжээ авдагийн дотор шилмэл омгийн малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг байна. Мөн судалгааны төсөл хэрэгжиж эхлэх шатанд Дорноговь аймгийн Засаг даргын зүгээс малжуулах сангийн төслийг сонгон хэрэгжүүлэх талаар санал илэрхийлж байсан бөгөөд төсөлд хамрагдсан сумдын зүгээс мөн ийм төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг шаргуу тавьж байсан юм. Энэ бүгдээс дүгнэхэд уг туршилтын төсөл нь оновчтой (зүй зохистой) байдлын үзүүлэлтээрээ маш өндөр байр эзэлж байна.

(2) Үр дүнтэй байдал

Сумын ЗДТГ-аас сангийн үйл ажиллагааг идэвхитэй удирдан зохион байгуулж эхний жилийн зээлээс буцаан төлөгдсөн малаас үргэлжлүүлэн 2 дахь жилийн зээлийг олгосон байна. Бүх хүлээгдсэн үр дүнгүүд биелж байгаа бөгөөд төслийн зорилго болох "Сумын ЗДТГ малын сан байгуулж ажилуулна" гэсэн зорилт биелэгдэхээр байна.

Өнөөг хүртэл малжуулах сангуудын хөрөнгө оруулалт хийж ирсэн малын тоо 50 орчим толгой мал байсныг уг төслөөр 1 өрхөд 100 орчим толгой мал байхаар шийдвэрлэж, хөрөнгө оруулалт хийгдэх малчныг сонгох ба тэдэнд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоход чухалчлан анхаарч ирсэн ба энэ нь гамшигт өртсөн малчин өрхийн орлогыг тогтвортой байлгахад нь бүрэн хүрэлцэхүйц тооны малтай болгох гэсэн загвар юм. Одоогийн байдлаар эхний жилийн хөрөнгө оруулалт хийгдсэн малчдын буцаан төлөлт зүй ёсоороо хийгдэн явж байгаа тул уг төсөл ган зудын гамшгаас хамгаалах арга хэмжээний загвар гэдэг утгаараа үр дүнтэй байдлын үзүүлэлт нь өндөр байна гэж дүгнэж байна.

(3) Үр ашигтай байдал

Сангийн үйл ажиллагааг сумын ЗДТГ-ын хүрээнд сумын Засаг дарга, ХАА-н түшмэл болон төрийн сангийн төлөөлөгч зэрэг 3 хүнээс бүрдэх "Малжуулах сангийн төлөөлөн удирдах зөвлөл" удирдан явуулж байна. Зөвлөл, эхний жил зээл олгосон малчдын буцаан төлөлтөд хяналт тавих, 2 дахь жилийн зээлд хамрагдах малчдыг сонгох, малчидтай уулзаж зөвлөлдөх зэргээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.

2004 оны 6, 7-р саруудад 21,095,357 төгрөг (ойролцоогоор 2 сая орчим иен)-ийн санхүүжилтээр сангийн эхний хөрөнгө болох 600 толгой малыг худалдан авч, 6 малчин өрхөд зээлээр олгосон. Сүхбаатар аймгийн нутгаас худалдан авсан нутгийн шилмэл омгийн малын гэрчилгээг газар дээр нь шууд авч чадаагүй зэрэг асуудал гарсан боловч энэ удаад уг гэрчигээг нөхөн авч, асуудлыг шийдвэрлэлээ. Малын зээлийн эхний жилийн буцаан төлөлт хувиарын дагуу (118 толгой байхаас 133) явагдсан.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эхний жил хөрөнгө оруулалт хийгдсэн 6 малчин өрхөөс гадна ойрын 6 жилийн хугацаанд 14 малчин өрхөд нийтдээ 1300 толгой малыг зээлээр олгохоор тусгасан байна. Ган, зудын гамшиг зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхгүй тохиолдолд, эхний жилийн үндсэн малд тулгуурлан төсөл хэвийн явагдаж, хүлээгдсэн үр дүнгүүд гарах төлөлтэй байгаа ба үр ашигтай байдлын үзүүлэлт сайн байна.

(4) Үр нөлөөлөл (төсөөлөл)

Энэхүү төслийг төсөл хэрэгжиж байгаа сум болон бусад сумын малчид ихээхэн сонирхож байна. Төслийн хүрээнд нийт 7 жилийн хугацаанд 20 малчныг хамруулан 1900 орчим толгой малыг зээлээр олгохоор тооцоолож байгаа бөгөөд зудаар үүссэн хохирлыг нөхөх, ядуурлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ болох магадлалтай юм. Малаа төлөвлөгөөтэй өсгөж чадвал өрхийн орлого нэмэгдэж, амьдралаа тогтворжуулах боломж бүрдэх тул малчид энэ төсөлд ихээхэн найдлага тавьж байна.

Тэрчлэн малжуулах сан хөл дээрээ зогсож чадсанаар төслөөр нийлүүлсэн шилмэл омгийн мал сумын хэмжээнд тархаж, сумын малын чанарыг сайжруулах зэрэг үр нөлөөллийг бий болгох найдлага төрж байна.

(5) Бие даан хөгжих чадвар (төсөөлөл)

Сангийн ашиглалтыг сумын ЗДТГ "Малжуулах сангийн журам"-ын дагуу явуулж байгаа бөгөөд цаашид ч сумын Засаг даргын удирдан, манлайлах идэвхитэй үйл ажиллагааны доор хэвийн явагдах болов уу. Төслийн үр шимийг хүртэгчид малын зээлийг буцаан төлөх талаар хүлээсэн хариуцлагаа сайтар ойлгож байгаа бөгөөд өнөө хүртэл хувиарын дагуу буцаан төлж ирсэн, цаашид ч саадгүй төлж, сангийн үйл ажиллагаа үргэлжлэн явагдах боломж харагдаж байгаа тул бие даан хөгжих чадвар өндөр гэж дүгнэж байна. Цаашид зуд болоход малчдад зээлээр олгосон малыг хорогдуулахгүйн тулд сумын ЗДТГ өвс тэжээл бэлдэх, нөөцлөх зэргээр өвөлжилтийн бэлтгэлийг сайтар зохион байгуулах нь төслийг хэвийн үргэлжлүүлж явахад чухал нөхцөл болох юм.

2-3. Үр дүнд гарахад нөлөөлсөн хүчин зүйл

Сумын "Малчдын өдөр" зэрэг арга хэмжээний үер иргэдэд төслийн үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ төслийн үр шимийг хүртэгчдэд бүхий л боломжийг ашиглан төслийн ач холбогдлыг ойлгуулсан. Энэ нь төсөлд хамрагдагсдын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, улмаар зээлээ өндөр үзүүлэлттэйгээр буцаан төлсөн үр дүнд хүргэсэн байна. Тэрчлэн төсөлд хамрагдсан малчдыг сайтар сонгон шалгаруулсан нь амжилтад хүргэсэн нэгэн хүчин зүйл болжээ. Мөн анх худалдан авсан малын тоо толгойг зээлийн буцаан төлөлтөөс дараагийн ээлжинд хамрагдах хүмүүст зээл олгож болох хэмжээнд тооцоолж чадсан нь чухал нөлөө үзүүлсэн байна.

2-4. Асуудал бэрхшээлийг үүсгэсэн хүчин зүйл

(1) Төслийн агуулгатай холбоотой хүчин зүйл

Төслийн хүрээнд малчдад зээлээр олгох бүх малыг Сүхбаатар аймгаас худалдан авахаар төлөвлөж байсан боловч, шилмэл омгийн малыг урьдынх шиг сүрэглэн маллахаа больсон тул айл айлаас цуглуулж авах шаардлагатай болсон, хол газар тээвэрлэхэд хүндрэлтэй зэрэг шалтгаанаар уг малын зөвхөн нэг хэсгийг худалдан авсан болно. Үлдсэн малыг урьд өмнө Сүхбаатар аймгаас худалдан авсан шилмэл омгийн малыг сүрэгтээ оруулсан малчдаас худалдан авсан болно.

(2) Хэрэгжилтийн үйл явцтай холбоотой хүчин зүйл

Зээлээр олгосон малын дотор эх үрийн холбоогүй хонь, хурга байна, туранхай, хөгшин үхэр өгсөн гэсэн гомдол зарим малчнаас гарсан болно.

2-5. Дүгнэлт

Малжуулах төслийн эхний жилийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэнээр "Малжуулах сангийн" ашиглалтын бүтэц, зохион байгуулалтын суурь тавигдлаа гэж үзэж байна. Сумын ЗДТГ "Малжуулах сангийн үйл ажиллагааг явуулж сурч, төсөл малчидад хүрч чадсанаар төслийг цаашид амжилттай үргэлжлүүлэн явах тааламжтай орчин бүрдлээ.

2-6. Зөвлөмж

Зээлд хамрагдах малчдыг сонгох арга хэлбэр, сангийн ашиглалтын журмыг тодорхой болгож, сангийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулна.

Одоогийн байдлаар төсөлд хамрагдах малчдад "Тодорхой хэмжээний малтай байх" нөхцөл тавьж байгаа боловч сумын ЗДТГ анхнаасаа тавьж ирсэн зорилт болох "Малгүй, ядуу малчдыг хамруулах" асуудлыг судалж үзэж байна. Гэвч энэ асуудлыг шийдэхийн тулд Эрдэнэ сумын ЗДТГ-аас төлөвлөж буй "Малгүй, ядуу малчдыг" тодорхой хэмжээгээр сургалтад хамруулах ажлыг бодитойгоор зохион байгуулах нь чухал юм.

2-7. Сургамж

- Сангийн ашиглалт болон зээлд хамрагдах малчдыг сонгох үйл ажиллагааг журмын дагуу явуулах нь үр дүнтэй байна. Сангийн ашиглалтыг тодорхой, ил тод, нээлттэй байлгаснаар малчдын итгэлийг хүлээж, цаашид үйл ажиллагаагаа амжилттай явуулах боломж бүрдэнэ.
- Зээлээр олгох малыг сонгон авах, хүлээлгэн өгөхдөө малын дотор эх үрийн холбоогүй мал, төл, туранхай, хөгшин мал оруулахгүй байхыг анхаарах шаардлагатай.
- Амьжиргаандаа мал их хэрэглэдэг өрх зээлээ буцаан төлж чадахгүй байдалд орж болзошгүй тул ийм өрхийг аль болох хамруулахгүй байвал зүйтэй.
- Сумын ЗДТГ болон багийн дарга нарын зүгээс анхаарал тавьж, зөвлөмж өгч байх нь малчдын санаа сэтгэлийг өргөх, ухамсарыг дээшлүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ байх болно.

2-8. Дагалдах ажлуудын талаар

- Сумын ЗДТГ-аас малчдын өвс, тэжээлийн бэлтгэл, ахуй амьдралын байдлыг анхааран, өвөлжилтийн бэлтгэлийг хангалттай хийлгэх шаардлагатай. Зээлийн буцаан төлөлтөд доголдол гарах юм бол буцаан хэвийн байдалд нь оруулахад ихээхэн хугацаа шаардагдана. Иймд зээлд хамрагдсан малчидын батлан даагчидтай нягт хамтран ажиллах нь чухал юм.
- Шилмэл омгийн эцэг малыг 2 жил тутамд сүрэг сэлгэн байршуулж байх шаардлагатай тул сумын ЗДТГ-аас үүнд анхаарал тавьж, мөрдөх хэрэгтэй. Үүний зэрэгцээ шилмэл омгийн малын тоо, толгойг өсгөхөд анхаарал тавих шаардлагатай.
- Сумын ЗДТГ 2 дахь жилээс зээлд хамрагдсан малчдад 100 хүрэхгүй толгой мал олгож эхэлсэн. Эдгээр малчдад анхаарал, халамж тавихын зэрэгцээ, ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд авах арга хэмжээг яаралтай судлан үзэж, заавар, зөвлөмж өгч байх шаардлагатай.
- Сумын ЗДТГ цаашид "малгүй, ядуу малчдыг" чинээлэг, туршлагатай малчдад хариуцуулан өгч мал маллах арга ухаанд сургах, улмаар "малгүй, ядуу малчин" төсөлд хамрагдах үед "чинээлэг, туршлагатай малчин" нь түүний батлан даагч болж ажиллах хэлбэрийг нэвтрүүлэхээр судалж байгаа. Энэ ажил амжилттай хэрэгжвэл "Малжуулах сан" нь "ядуурлыг бууруулах" үр дүнтэй арга хэрэгсэл болох юм. Иймд үүнийг сайтар судалж үзсэний үндсэн дээр хэрэгжүүлбэл зохино.

4.7.3 Бүрдэний сувилалд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

<p>1. Төслийн тойм</p> <p>*Хамрагдах сум : Эрдэнэ сум, Бүрдэний сувиллын газар, түүний орчмын нутаг</p> <p>* Хамрагдсан бүлэг : Эрдэнэ сумын ЗДТГ</p> <p>* Хэрэгжүүлэх байгуулга :Эрдэнэ сумын ЗДТГ</p>
<p>1-1 Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм</p> <p>Зуны улиралд (6- 8 сард) ажилладаг сувиллын газрын менежмент сайжирснаар ойр хавийн малчдын хувьд сүүн бүтээгдхүүн борлуулах боломж нээгдэж, тэр хэмжээгээр бэлэн мөнгөний орлого өссөнөөр өрхийн төсөв тогтворжих боломжтой болж байна.Тэрчлэн ингэний сүү нийлүүлэх боломж нэмэгдсэнээр малчид түүний зах зээлийн үнэ цэнийг мэдэрч, бүлгийн зохион байгуулалттайгаар борлуулалт хийх хэлбэр бий болох боломжтой юм. Энэ нь малчдын үйлдвэрлэсэн,борлуулсан бүтээгдхүүнийг нийлүүлэх зах зээлийг тогтвортой байлгахад нөлөөлөх болов уу гэж найдаж байна.</p> <p>1-2 Хамтын ажиллагааны агуулга</p> <p>(1) Зорилго</p> <p>1) Төслийн зорилго Бүрдэний сувиллын газрын менежмент сайжирах</p> <p>2) Эрхэм зорилго Бүрдэнэ дэхь сувиллын газрын ойролцоо нутагладаг малчдын бэлэн мөнгөний орлого нэмэгдэх</p> <p>(2) Үр дүн Үр дүн 1) Сувилалд хавь орчны малчдаас худалдан авах сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ нэмэгдэнэ. Үр дүн 2) Бүрдэнэ дэхь сувиллын газрын үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ.</p> <p>(3) Хөрөнгө оруулалт, оролцоо (Input)</p> <p>Японы тал: Судалгааны багийн гишүүд, ус цэвэршүүлэх төхөөрөмж (420,000 иен) Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг байрлуулах байшин барихад шаардагдах эд материал (140,000 иен)</p> <p>Сумын ЗДТГ: Сумын Засаг дарга, багийн засаг дарга, ХАА-н түшмэл, байгууламж барих ажилчдын цалин хөлс</p> <p>Малчдын бүлэг: Малчдын бүлгийн гишүүд, түүхий эд (сүү),сүүн бүтээгдэхүүн боловсруулахад шаардагдах зардал, зөөвөрлөлтийн зардал</p>
<p>2. Үнэлгээний үр дүн</p> <p>2-1. Үйл ажиллагааны ололтын шалгуур, нотолгоо</p> <p>(1) Төслийн зорилго Төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнөх жил болох 2003 онд жилийн гүйцэтгэлээр 203,250 төгрөгийн алдагдал хүлээж байсан бол 2004 онд төслийн үр дүнд 247,530 төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин 2005 онд 25,782 төгрөг болж ашиг нь буурсан байна. Гэвч Сумын ЗДТГ орлогын байдал сайжирсанд *тун сэтгэл ханамжтай байгаа бөгөөд төслийн зорилго биелэсэн гэж үзэж байгаа. (Энэ ашигт нь ус цэвэрлэгч төхөөрөмжийн элэгдэл хорогдлын шимтгэлийг оруулан тооцсон байгаа. Сумын ЗДТГ ашгаас ус цэвэрлэх төхөөрөмжийн элэгдэл хорогдлын шимтгэлийн хасаж тооцоогүй байгаа тул 2004 оны ашиг 807 530 төгрөг, 2005 оны ашиг 234,480 төгрөг болж байгаа юм.)</p> <p>(2) Үр дүн Үр дүн 1) Сувилалд хавь орчны малчдаас худалдан авах сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ нэмэгдэнэ. Малчдаас худалдан авдаг ингэний боловсруулсан сүүний үнэ төсөл эхлэхийн өмнөх 2003 онд 538,260 төгрөг байсан бол төсөл хэрэгжиж эхэлсэн 2004 онд 900,354 төгрөг (2003 оныхтой харьцуулахад 67%-иар өссөн), 2005 онд 945,869 төгрөг (2003 оныхоос 76%-иар өссөн) болж, зорилгодоо нэгэнт хүрсэн байлаа. Харин, нийт худалдан авсан хэмжээ нь ингэний сүү, ямааны сүү хоёрыг нийлүүлээд 2003 онд 1,307 литр байсан ба 2004 онд 1623 литр (2003 онтой харьцуулахад 24%-иар өссөн), 2005 онд 1,803 литр (2003 оныхтой харьцуулахад 38%-иар өссөн) болсон нь зорьж байсан хэмжээ(100-160% өсгөх)-нд хүрээгүй байна.</p>

Үр дүн 2) Бүрдэнэ дэхь сувиллын газрын үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ.

2005 оны гүйцэтгэлээр сувиллын нийт үйлчлүүлэгчдийн тоо төсөл хэрэгжиж эхлэхийн өмнөх жил болох 2003 онтой харьцуулахад 45%-иар өсч 174 хүнд хүрсэн бөгөөд тэдгээрийн үйлчлүүлсэн нийт хугацаа 44%-иар уртсаж 1,960 хоног болж, өндөр үр дүнд хүрсэн гэж дүгнэхээр байна.

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой (зүй зохистой)байдал

Бүрдэнэ дэх сувиллын газарт ингэний боловсруулсан сүүг эмчилгээний журмаар сувилуулагчдад өгдөг бөгөөд сувилал нь эмчилгээнд ашиглах сүү, цагаан идээгээ нутгийн малчдаас худалдан авдаг байна. Орон нутгийн суурь хөгжлийн нэгэн хэсэг болгож, Бүрдэнэ дэх сувиллын газрын үйлчилгээ, менежментийг сайжруулан, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлснээр ингэний боловсруулсан сүү болон цагаан идээний хэрэгцээ нэмэгдэж, цагаан идээ бэлтгэн нийлүүлэгчид болох нутгийн малчдын орлого нэмэгдэх юм. Сувиллын газрын үйлчилгээ, удирдлага менежментийг сайжруулах нь сумын ЗДТГ-ын чухал зорилт бөгөөд басхүү, малчдын ядуурлыг бууруулах, тэдний амьжиргааг сайжруулахад дэм болох гэдэг утгаараа уг төслийн зүй зохистой (оновчтой) байдлын үзүүлэлт өндөр гэж дүгнэж байна.

(2) Үр дүнтэй байдал

"Үр дүн 1: Сувиллын газар, нутгийн малчдаас худалдан авах сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ нэмэгдэх" гэсэн байгаа. Сувиллын газрын малчдаас худалдан авах бүтээгдэхүүний мөнгөн дүнгийн хэмжээ 76%-иар өссөн нь анх зорьж байсан 40%-иас илт давж, биелсэн байна. Худалдан авсан хэмжээний хувьд 38%-иар өссөн нь анх зорьж байсан 100-160%-иас доогуур байгаа юм. Мөн, "Үр дүн 2: Сувиллын газрын үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэх" гэдгийн тухайд 45% өссөн үзүүлэлттэй байна. "Үр дүн 1, 2"-ын биелэлтийг үзвэл сувиллын газрын менежмент сайжирсан, төслийн зорилго ерөнхийдөө биелэгдсэн гэж үзэж болно.

Сувиллын газарт сүү, цагаан идээ борлуулах төслийн үйл ажиллагаа

- Төсөл эхлэхийн өмнөх (2003 он) үеэс өнөөг хүртэл -

	2003	2004		2005	
Сувилуулагчдын тоо	120	141	(18%)	174	(45%)
Малчдын борлуулсан бүтээгдэхүүний нийт хэмжээ (л). (Сувиллын газрын худалдан авсан нийт хэмжээ)	1,307	1,623	(24%)	1,803	(38%)
Ингэний сүү	976	1,201	(23%)	1,381	(42%)
Ямааны сүү	331	423	(28%)	422	(27%)
Малчдын нийт орлого(төг). (Сувиллын газрын сүү худалдан авсан мөнгөн дүн)	538,260	900,354	(67%)	945,896	(76%)
Борлуулалт явуулсан малчдын бүлгийн тоо	3	4		4	

*Хаалтан доторх %-иар гаргасан үзүүлэлт нь 2003 оныхтой харьцуулахад хэдэн % өссөний үзүүлэлт болно.

(3) Үр ашигтай байдал

Төслийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдсан. 2004 оны 7 сард сувиллын газрын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд ус цэвэршүүлэх төхөөрөмж нийлүүлсэн боловч "Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл"-ийн хүрээнд тус сувиллын ойролцоо шинээр гаргасан худгийн усны чанар муугаас (төмрийн агууламж өндөр) ус цэвэршүүлэгчийн шүүлтүүрт эвдрэл учруулсан болно. Үүний дараагаар "Гар худаг гаргах кампанит ажил өрнүүлэх төсөл"-ийн хүрээнд Эрдэнэ сумын ЗДТГ-аас сувиллын газрын ойролцоо шинээр гар худаг гаргасан бөгөөд энэ худгийн усыг цэвэршүүлэн хэрэглэх зорилгоор ус цэвэршүүлэх төхөөрөмжийг дахин ашиглаж эхэлсэн байна. Тэгээд ЗДТГ-ын ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр цэвэршүүлсэн ус, сайн чанарын ингэний сүү идэвхтэйгээр сурталчилсны үр дүнд үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн.

Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн фильтр (шүүлтүүр)-ийг тогтмол хугацаанд солих шаардлагатай бөгөөд сувиллын газрын ашиг орлогын түвшин өнөөгийнхтэй адил тогтвортой сайн байх тохиолдолд шүүлтүүрийг хэрэгтэй үедээ захиалж авахад онцын бэрхшээл гарахгүй байж, ус цэвэршүүлэх төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ тогтмол байж чадах болов уу гэсэн найдлага төрж байна.

Орон нутгийн мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд сувиллын газарт нийлүүлсэн ус цэвэршүүлэгч төхөөрөмжийн хувьд үр ашигтай байдлын үзүүлэлт сайн байна гэж дүгнэж болно.

(4) Үр нөлөөлөл

Бүрдэний сувиллын ашиг орлогын байдал сайжирч, сувилуулагчдын тоо өссөнөөр худалдан авах сүү,сүүн бүтээгдхүүний хэмжээ, үнэ нэмэгдэж, ойр хавийн малчид түүний үр шимийг хүртлээ. Ингэснээр өрх бүрийн бодит орлого өссөн байна.

Сүү,сүүн бүтээгдхүүний борлуулалтаас малчин өрх бүрийн олсон орлогын байдал

	2003 он (Эхлэхийн өмнө)	2004 он	2005 он
Дундаж орлого (төг / өрх)	179,000	225,000	236,000
2003 онтой харьцуулсан өсөлтийн хувь	-	26%	32%

Ноолуураас өөр орлогын шинэ эх үүсвэр болж чадах юм цаашид малчид тэмээний сүүний зах зээлийн үнэ цэнийг мэдэрч, тэмээ өсгөж эхэлбэл ойр хавийн бэлчээрийг бод малын зориулалтаар үр дүнтэй ашиглах боломж нээгдэж болох юм. Тэрчлэн малчид сувилалд нийлүүлэх сүүний хэмжээ, хугацааг дотроо зохицуулж, бүлгээр ажиллах сэтгэл зүй төлөвшиж эхэлж байна.

(5) Бие даан хөгжих чадвар(төсөөлөл)

Сувиллын газрын менежмент цаашид улам сайжирвал төслийн бие даан хөгжих чадвар өндөр байна.

2-3. Үр дүн гарахад нөлөөлсөн хүчин зүйл

- Энэ сувилал нь Эрдэнэ сумын ЗДТГ-т харьяалагддаг тул сумын Засаг даргын удирдан зохион байгуулах үүрэг төслийн үр дүн гарахад ихээхэн хувь нэмэр оруулсан байна.
- Сувилалд сүү нийлүүлдэг малчдын бүлгийн гишүүд нийлүүлэх сүүний хэмжээ, хугацаа, ээлж дарааллаа дотроо зохицуулж чаддаг болсон.

2-4. Асуудал, бэрхшээл ба асуудал, бэрхшээл үүсгэсэн хүчин зүйл

(1) Төслийн агуулгатай холбоотой хүчин зүйл

Энэхүү төсөл нь бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөлтэй холбогдож, малчдын бүлгийн зохион байгуулалтаар худаг ашиглах үйл ажиллагаа явуулах ёстой байлаа. Гэвч Бүрдэнд гаргасан худгийн усны чанар муу (төмөрлөгийн хэмжээ 34мг/л) байсан тул худаг ашиглах малчдын бүлэг байгуулагдаагүй болно.

(2) Хэрэгжилттэй холбоотой хүчин зүйл

Сумын ЗДТГ- аас сувиллын газрын тоо бүртгэлд сайтар хяналт тавьж байгаа тул ямар нэгэн доголдол байхгүй байна.

2-5. Дүгнэлт

Сувиллын газрын менежмент сайжирч, тэр хавийн малчдын орлого нэмэгдсэнээр төслийн зорилго, эрхэм зорилтын аль аль нь биелэгдсэн байна. Мөн тус төслийг дамжуулан хөдөө орон нутгийг хөгжүүлэх (сайжруулах) асуудал амжилтад хүрсэн гэж хэлж болно. Малчдын орлогыг улам бүр нэмэгдүүлэхийн тулд малчдын зохион байгуулалттай үйл ажиллагаа болон сүү, сүүн бүтээгдхүүний борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2-6. Зөвлөмж

Орон нутагт мал аж ахуйн бүтээгдхүүний хэрэглэгчид шинээр гарч ирсэн тохиолдолд ойр хавийн малчид бүлэг болон нэгдэж, сүү,сүүн бүтээгдхүүнийг зохион байгуулалттайгаар үйлвэрлэн нийлүүлэх нь тэдний орлого өсөхөд нөлөөлөх тул орон нутгийн засаг захиргаа малчдыг бүлэг болгон зохион байгуулахад анхаарал тавьж байх нь зүйтэй юм.

2-7. Сургамж

Орон нутагт мал аж ахуйн бүтээгдхүүний борлуулалтын цэг байгуулах тохиолдолд (орон нутгийн борлуулалтын цэг) ойр хавийн малчдыг зохион байгуулалтад оруулан, хорших хэлбэрийн үйл ажиллагаа явуулбал харьцангуй өндөр амжилтанд хүрч болно.

2-8. Дагалдах ажлын тухайд

Төслөөр нийлүүлсэн ус цэвэрлэгч төхөөрөмжийн шүүлтүүрийг тодорхой хугацаанд сольж байх шаардлагатай тул үйлдвэрлэгч, нийлүүлэгч, үнийн тухай мэдээллийг сумын ЗДТГ өгөх шаардлагатай болно.

4.7.4 Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

<p>1. Төслийн тойм</p> <p>Хэрэгжүүлэх газар: Эрдэнэ сум Хамрагдах бүлэг: Малчдын бүлэг Хэрэгжүүлэгч байгууллага: Сумын ЗДТГ, малчдын бүлэг</p> <p>1-1 Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм</p> <p>Малчдын бүлэг сумын ЗДТГ-аас зээлээр олгох хөргөгчийг ашиглан ингэний сүү, сүүн бүтээгдхүүнийг сумын төвд хуримтлуулан борлуулах, цаашид аймгийн төв Сайншанд, Замын-Үүдэд жилийн турш борлуулах замаар зах зээл, борлуулалтын сүлжээгээ өргөтгөснөөр малчдын бэлэн мөнгөний орлого нэмэгдэж, өрхийн төсөв сайжран, тогтворжих боломжтой болно.</p> <p>1-2 Хамтын ажиллагааны агуулга</p> <p>(1) Зорилго</p> <p>1) Төслийн зорилго "Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хамтран борлуулах тогтолцоо бий болох"</p> <p>2) Эрхэм зорилго "Малчдын бэлэн мөнгөний орлого нэмэгдэх"</p> <p>(2) Үр дүн</p> <p>1) Малчдын сүү, сүүн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх</p> <p>2) Сүү, сүүн бүтээгдхүүний борлуулалтын хэмжээ нэмэгдэх</p> <p>3) Сүү, сүүн бүтээгдхүүний борлуулалтын менежмент тогтворжих</p> <p>(3) Хөрөнгө оруулалт, оролцоо (Input)</p> <p>Японы тал:</p> <p>Судалгааны багийн гишүүд, Хөргөгч, хөлдөөгч, цахилгаан хэрэглэдэггүй хөргөгч бүтээгдэхүүн тээвэрлэхэд ашиглах сав</p> <p>Сумын ЗДТГ:</p> <p>Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга, ХАА-н түшмэл</p> <p>Малчдын бүлэг:</p> <p>Малчдын бүлгийн гишүүд, түүхий эд (сүү), малчдын бүлгийн хариуцах зардал (Тонг төхөөрөмжийн үнийн нэг хэсэг буюу 551000 төгрөгийг сумын санд буцаан төлөх), эргэлтийн хөрөнгө, тээврийн зардал</p>
<p>2. Үнэлгээний үр дүн</p> <p>2-1. Үйл ажиллагааны ололтын шалгуур, нотолгоо</p> <p>(1) Төслийн зорилго</p> <p>Зуны борлуулалтаар тодорхой хэмжээний орлого олсон. Гэхдээ энэ зун гантай байснаас бэлчээр муу, сумын төвөөс алслагдсан бэлчээрт отроор нүүж очсон тул төлөвлөсөн хэмжээнд үйлдвэрлэл, борлуулалт хийж чадаагүй. Гэвч бага хэмжээнд ч гэсэн бүлгийн үйл ажиллагаа явагдаж, сумын төвөөс гадна төмөр замаар зөөвөрлөн борлуулалт хийсэн. Зээлээр олгосон тоног төхөөрөмжийг ашиглан сүү, сүүн бүтээгдхүүн зах зээлд нийлүүлэх зохион байгуулалтыг бий болгож чадсан гэж үзэж байна.</p> <p>(2) Үр дүн</p> <p>Үр дүн 1) Малчдын сүү, сүүн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх</p> <p>Энэ зун хур бороо багатай байснаас бэлчээрийн байдал муу, үйлдвэрлэл, борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй. Хэдий бага ч гэсэн энэ зуны 6, 7, 9-р саруудад борлуулалт хийгдсэн байна</p> <p>Үр дүн 2) Сүү, сүүн бүтээгдхүүний борлуулалтын хэмжээ нэмэгдэх</p> <p>2005 оны 6-р сард тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, бүлэг үйл ажиллагаагаа эхэлсэн. Гэхдээ энэ зун хур бороо бага, бэлчээрийн байдал маш муу байсан зэрэг гадаад нөхцөл байдлын улмаас сүү, сүүн бүтээгдхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг төлөвлөсөн хэмжээнд хүргэх боломжгүй байсан тул биелээгүй.</p> <p>Үр дүн 3) Сүү, сүүн бүтээгдхүүний борлуулалтын менежмент тогтворжих</p> <p>Төсөл эхэлээд удаагүй байгаа тул дүгнэлт хийхэд эрт байна. Бэлчээрийн байдал хэмээх гадаад хүчин зүйлээс ихээхэн шалтгаалах боловч борлуулалтаа үргэлжлүүлэн явуулж чадвал ашиг гарч, үйл ажиллагаа тогтворжих боломж байгаа. Сумын төвөөс гадна төмөр замаар зөөвөрлөн Замын-Үүдэд борлуулсан.</p>

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой (Зүй зохистой) байдал

Төслийн зорилго нь "Сум хөгжүүлэх сан"-гаас олгогдох тусламжаар дамжуулан малчид сүү, цагаан идээгээ жил тойрон борлуулах тогтолцоог бий болгох явдал бөгөөд тэдэнд бэлэн мөнгөний орлого олох 3-дагч эх үүсвэрийг нээж өгөхөд оршино. Үүний зэрэгцээ уг төсөл нь сумын ЗДТГ-аас орон нутгийн мал аж ахуйг сайжруулах арга хэмжээний нэгэн загвар ч болж болох юм. Иймд төслийн зүй зохистой (оновчтой) байдлын үзүүлэлт маш сайн гэж дүгнэж байна.

Тэрчлэн энэ төслийн хүрээнд бүтэн жилийн турш сүү, сүүн бүтээгдхүүн нийлүүлдэг болохын тулд эхлээд зуны улиралд нийлүүлэх зохион байгуулалтыг бий болгохыг зорьж байгаа бөгөөд энэ нь 2003 онд УИХ-аас баталсан "Малын гаралтай түүхий эд, бүтээгдхүүнийг хадгалах, тээвэрлэх, боловсруулах технологийг боловсронгуй болгох" тухай Хүнс Хөдөө Аж Ахуйн салбарт төрөөс баримтлах бодлогод нийцэж байгаа юм. Тэрчлэн 2002 онд сумын ИТХ-аар баталсан Эрдэнэ сумын мал аж ахуйг хөгжүүлэх Нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан "Цагаан хувьсгалыг" хэрэгжүүлэх зорилтод нийцэж байгаа юм.

(2) Үр дүнтэй байдал

Энэ зун бороо хур багатай байснаас бэлчээрийн байдал маш муу, малчдын бүлэг сайн бэлчээр хайж, борлуулалт хийдэг газраасаа холдон нүүж, оторт гарахаас өөр аргагүй болсон байна. Энэхүү гадаад нөхцөл байдлын нөлөөгөөр бүтээгдэхүүний зөөвөрлөлт, борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.

Гэвч хэдийгээр бага хэмжээгээр ч гэсэн тодорхой үйл ажиллагаа явуулсан тул нь гадаад нөхцөл байдлын нөлөөлөл байхгүй тохиолдолд төслийн зорилго болох "Жилийн турш нийлүүлэх тогтолцоог" бий болгож болно гэж үзэж болох болов уу.

(3) Үр ашигтай байдал

Хөрөнгө оруулагч болох сумын ЗДТГ-аас малчдын бүлэгтэй зөвшилцөж, бүлгийн үйл ажиллагааны агуулгын талаар ойлголттой болж, буцаан төлөлтийн төлөвлөгөө (график)-г зохиосноос гадна, малчдын бүлгийн үйл ажиллагаанд мониторинг хийж байна. Уг төслийн хяналтад идэвх гарган ажиллаж байгаа зэргээс нь үзэхэд төсөл цаашид үргэлжлэн тогтвортой явагдах ирээдүй байна гэж үзэж байна. Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн хувьд цаг хугацаандаа төлөвлөгөөний дагуу бүрэн хэмжээгээр нийлүүлэгдсэн. Харин цахилгаан хэрэглэдэггүй хөргөгчийн дотор талын температур хангалттай буухгүй байснаас ашиглагдаагүй тул үр дүн гарахад нэмэр болоогүй байна.

(4) Үр нөлөөлөл

Төсөлд хамрагдсан малчид бэлэн мөнгөний орлогын шинэ эх үүсвэр нээгдэж, бодит орлого нэмэгдсэнд сэтгэл ханамжтай байгаа бөгөөд төсөлд өндөр үнлэлт өгч байна. Мөн бүтээгдхүүний чанарыг хэрэглэгчид өндөрөөр үнэлж байна. Энэ бүлэг нь сумын төв, суурин зэрэг эрэлт хэрэгцээ ихтэй газар бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаагаараа хэрэглэгчдийн хувьд ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа явуулж байна.

(5) Бие даан хөгжих чадвар

Бүлэг идэвхитэй үйл ажиллагаа явуулж, тодорхой хэмжээнд орлогоо нэмэгдүүлэх боломж харагдаж байгаа тул цаашид бие даасан тогтвортой үйл ажиллагаа явуулах чадвартай гэж үзэж байна. Тэрчлэн сумын ЗДТГ энэ бүлгээс сумын худгийн санд буцаан төлөх хөрөнгө оруулалтын зардлаас 2 дахь, 3 дахь гэх мэтчилэн дараа, дараагийн бүлгүүдийг байгуулан санхүүжүүлж явах нь сумын мал аж ахуйн хөгжлийг дэмжих үүднээс чухал ач холбогдолтой юм.

2-3. Үр дүнтэй болоход нөлөөлсөн хүчин зүйл

- Төсөлд хамрагдсан малчид үйл ажиллагааныхаа тэмдэглэлийг үнэн зөв хөтөлж байсан нь орлого зарлагын тооцоо хийхэд үндэслэх материал болсон. Ингэснээр менежментийн талаар анхны ойлголттой болж, зардал их гардаг зүйлүүдийг олж илрүүлэн, нийлүүлэлтэндээ энэ бүхнийг анхааран ажилласан байна. Мөн ашиг гаргахын тулд янз бүрийн санаачлага, оролдлого хийж байна.

- Малчдын бүлгийн гишүүд үүрэг хариуцлагаа сайтар ухамсарлаж, хөрөнгө оруулалтын зардлаа буцаан төлөх эрмэлзэл дүүрэн байна.

2-4. Асуудал бэрхшээл ба асуудал бэрхшээл үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйл

- Гадаад нөхцөл байдлын нөлөөллөөр төлөвлөсөн хэмжээнд үйлдвэрлэл, борлуулалт хийж чадаагүй.
- Гэрийн нөхцөлд зуны улиралд сүүн бүтээгдхүүн хадгалах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор туршилтын журмаар цахилгаан хэрэглэдэггүй хөргөгч нийлүүлсэн боловч үр дүн гарсангүй. Иймд малчид сүүгээ гэртэй тодорхой хэмжээнд хуримтлуулах боломжгүй болж байнга зөөж байхад хүрсэн байна. Цахилгаан хэрэглэдэггүй хөргөчийг хэвийн ажиллуулахын тулд дулаан үл нэвтрүүлэх хулдаас нийлүүлсэн бөгөөд ирэх зун дахин туршиж үзэх шаардлагатай юм.

2-5. Дүгнэлт

Багахан хэмжээний хөрөнгө оруулалтыг үр бүтээлтэй ашиглаж, тодорхой амжилтанд хүрч байгаагаас үзэхэд энэ төслийн үр дүнтэй байдлын үзүүлэлт өндөр байна. Тэрчлэн малчдын орлогыг нэмэгдүүлэх боломжыг олгож байгаагаараа ихээхэн үр нөлөөлөлтэй юм.

2-6. Зөвлөмж

Улсын төсвөөс сумын хөгжлийн санд тодорхой хөрөнгийн дэмжлэг үзүүлж, сангаас иргэдийн аж ахуйн үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар энэ төсөлтэй адил төстэй төслүүдийг хэрэгжүүлэн, орон нутгийн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа явуулахыг зөвлөө.

2-7. Сургамж

- Сумын хөгжлийн сангаас олгож байгаа зээлийг орон нутгийн мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд үр бүтээлтэй ашиглаж болно.
- Сүү, сүүн бүтээгдхүүний нийлүүлэлт, борлуулалтын зохион байгуулалтыг бий болгоход малчдын бүлгийн зохион байгуулалттай үйл ажиллагаа үр дүнтэй болох нь харагдлаа.
- Зуны улиралд сүү, сүүн бүтээгдхүүний хадгалалтыг сайжруулах зорилгоор цахилгаан хангамжгүй малчдын гэрт ашиглахад тохиромжтойг нь бодож цахилгаан хэрэглэдэггүй хөргөгч нийлүүлсэн боловч анх ашиглаж байгаа хүмүүст ашиглалтын арга технологийг сайтар зааж өгөх шаардлагатай байсан байна. Гарын авлага бэлдэж, ашиглагчдад тараах нь зүйтэй.

2-8. Дагалдах ажил

- Өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын буцаан төлөлт хуваарийн дагуу явагдлаа. Цашид сумын ЗДТГ бүлгийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн мониторинг хийж байх шаардлагатай.
- Сумын хөгжлийн сан дараагийн ээлжинд зээл олгох төсөл, төслийн агуулгыг судлан шалгаруулж, сумын ЗДТГ малчдын бүлгийг зохион байгуулж явах нь зүйтэй.
- Ажиллахгүй байгаа цахилгаан хэрэглэдэггүй хөргөгчийн асуудлыг үйлдвэрлэгч нь болохтөрийн бус байгуулгад (МОРП) тавьж арга хэмжээ авч өгөхийг шаардах хэрэгтэй.

4.7.5 Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

1. Төслийн тойм

* Хамрагдах сумууд: Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сум

* Хамрагдах бүлэг: Сумын төвийн иргэдийн бүлэг

* Хэрэгжүүлэгч байгууллага : Сумын ЗДТГ, иргэдийн бүлэг

1-1 Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм.

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, мал аж ахуйгаас бусад орлогын эх үүсвэрийг бий болгохын тулд хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилт хийж, иргэдийн бүлгийг ноос хадгалах, боловсруулах сургалтанд хамруулснаар мал аж ахуйн бүтээгдхүүний борлуулалт нэмэгдэж, сумын хэмжээнд хонины ноос боловсруулах үйл ажиллагаанд ахиц гарна. Энэ нь төсөлд хамрагдсан иргэдийн бүлгийн гишүүдийн бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэхийн хамт малчдын хувийн хэрэгцээнд бага хэмжээгээр ашиглагдах төдий байгаа (хялбар боловсруулалт хийж гэрийн эсгий хийдэг) хонины ноосыг үр бүтээлтэй ашиглах боломжийг олгож, ингэснээрээ малчдын бэлэн мөнгө олох боломжийг нэмэгдүүлж, улмаар малчин өрхийн амьжиргааг тогтворжуулахад хувь нэмэр болно гэж найдаж болох юм.

1-2 Хамтын ажиллагааны агуулга

(1) Зорилго

1) Төслийн зорилго

"Сум орон нутагт (хонины ноос боловсруулах) жижиг үйлдвэрлэлийг бий болгох хялбар арга замыг хөнгөлөлттэй зээлийн тусламжтайгаар шийдвэрлэх"

2) Эрхэм зорилго

"Сумын иргэдийн бэлэн мөнгөний орлого нэмэгдэх"

(2) Үр дүн

1) Хонины ноосыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх

2) (Хонины ноосон бүтээгдэхүүний борлуулалт тогтвортой явагдах

(3) Хөрөнгө оруулалт, оролцоо

Япон тал:

Судалгааны багийн гишүүд

Ноос боловсруулах тоног төхөөрөмж болон үйлдвэрийн засвар үйлчилгээний зардал (3 сумд нийт 1.7 сая иен), ижил төрлийн үйлдвэрлэлтэй танилцах сургалтын хөтөлбөр (75,000 иен)

Сумын ЗДТГ:

Сумын Засаг дарга, Багийн засаг дарга, ЗДТГ-ын ХАА-н түшмэл, «Сумын хөгжлийн сан»-гийн хариуцагч

Үйлдвэрлэл явуулах байр (Хөвсгөл, Эрдэнэ сумууд)

Иргэдийн бүлэг:

Иргэдийн бүлгийн гишүүд, түүхий эд, эргэлтийн хөрөнгө, эхний хөрөнгө оруулалт (1 хэсэг), боловсруулах жижиг цех (Улаанбадрах сумын бүлэг)

2. Үнэлгээний үр дүн

2-1. Үйл ажиллагааны ололтын шалгуур, нотолгоо

(1) Төслийн зорилго

Хөнгөлөлттэй нөхцөлөөр хөрөнгө оруулалт хийгдэн, төсөлд хамрагдсан 3 суманд бага оврын ноос боловсруулах үйлдвэрлэл явагдаж эхэлснээр төслийн зорилго тодорхой хэмжээнд биелсэн гэж үзэж байна. Бүх бүлгүүд эхний ээлжийн буцаан төлөлтөө хийсэн байна. Төслийн эрхэм зорилгыг биелүүлэн хавь орчны малчдад үр дүнг нь хүргэхийн тулд бүх бүлгүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, тогтвортой явуулах шаардлагатай.

(2) Үр дүн

Үр дүн 1) Хонины ноосыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх

3 бүлэг үйлдвэрлэлээ эхэлснээр дээрхи үр дүнд хүрсэн байна. Цаашид арга, туршлага хуримтлуулан бүтээгдэхүүний чанарыг улам сайжруулан, үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээгээ нэмэгдүүлэхийг зорих шаардлагатай. Мөн цаашид үргэлжлүүлэн мониторинг хийж явах шаардлагатай.

Үр дүн 2) Хонины ноосон бүтээгдэхүүний борлуулалт тогтвортой явагдах

Хэдийгээр үйлдвэрлэлээ эхэлсэн боловч цаашид сумын худгийн санд хөрөнгө оруулалтын зардалыг буцаан төлөхийн хамт, ашигтай, тогтвортой үйл ажиллагаа явуулах зорилт тулгарч байна. Буцаан төлөх хуваарьт өөрчлөлт оруулснаар борлуулалтыг тогтвортой явуулах боломж бүрдсэн гэж үзэж байна. Цаашид мониторинг хийж явах шаардлагатай.

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой (Зүй зохистой) байдал

Төслийн зорилго нь сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох замаар сум орон нутагт хонины ноос боловсруулах жижиг үйлдвэрлэл явуулж, сумын иргэдийг ажлын байртай болгох, нөгөө талаар үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлэх малчдын орлогыг нэмэгдүүлэн өрхийн амьжиргаа, орлогын түвшинг тогтворжуулахад хувь нэмэр оруулах явдалд оршино.

Бэлэн мөнгөний орлогын хомсдолтой орон нутгийн малчид, иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах магадлалтай гэж хэлж болно. Монгол улсын "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"(2003 он)-т ядуурал болон ажилгүйдлийн түвшинг бууруулах, ард иргэдийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулах асуудал нь нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай үндсэн зорилтууд гэж заасан байдагтай тус төслийн зорилго, үйл ажиллагааны чиглэл бүрэн нийцэж байна.

(2) Үр дүнтэй байдал

Сумын иргэдэд ажлын байр бий болгох, түүхий эд нийлүүлэгч малчдын орлогыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн эерэг үр нөлөөтэй тул сум орон нутгийн хөгжил ба орон нутгийн мал аж ахуйн тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээний нэг болсон үр дүнтэй төсөл юм.

"Үр дүн 1: Хонины ноосоор хийх бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болох" болон "Үр дүн 2: Хонины ноосоор хийх бүтээгдэхүүний борлуулалт тогтвортой явагдах"-ын тухайд үйлдвэрлэл бодитоор явагдаж, борлуулалт ч үргэлжлэн хийгдэж байгаа хэдий ч бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба борлуулалтын хэмжээ төлөвлөж байснаас нэлээн доогуур байна. Үүнээс шалтгаалан ашгийн хэмжээ хангалтгүй байгаа тул буцаан төлөлтийн төлөвлөгөө (график)-нд өөрчлөлт оруулахаас аргагүй болсон. Төслийн зорилго болох "Сум орон нутагт (хонины ноос боловсруулах) жижиг үйлдвэрлэлийг бий болгох хялбар арга замыг хөнгөлөлттэй зээлийн тусламжтайгаар шийдвэрлэх" зорилго бүрэн биелэх эсэх нь өөрчлөн засагдсан буцаан төлөлтийн төлөвлөгөөг сумын ЗДТГ ба сумын иргэдийн бүлэг хэрхэн барьж ажиллахаас хамаарах тул мониторингийг үргэлжлүүлэн хийж явах шаардлагатай.

Төслийн хүрээнд нутгийн иргэдийн бүлгүүдэд зээлийн хүүгүй, 2 дахь жилээс эхлэн 5 ба 7 жилийн хугацаанд анхны хөрөнгө оруулалтын зардлын 80% болон 50%-ийг буцаан төлөх нөхцөлтэй зээлээр хонины ноос боловсруулах тоног төхөөрөмжийг нийлүүлсэн болно. Өнөөг хүртэл 3 бүлгийн аль алинд нь менежментээ сайжруулах зааварчилга өгсөөр ирсэн боловч бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт төлөвлөсөнд хүрээгүй байдалтай байгаагаас ашиг нь ч төлөвлөснөөр бус байгаа тул буцаан төлөлтийн нөхцөлд өөрчлөлт оруулахаас өөр аргагүй байдалд орлоо. Эцсийн дүнд буцаан төлөлтийн төлөвлөгөө 10 жил, 20 жил болон уртассан тул сумын ЗДТГ удаан хугацааны туршид буцаан төлөлтийн хяналтыг хийж явах шаардлагатай боллоо.

(3) Үр ашигтай байдал

Хөрөнгө оруулалтын чанар, цаг хугацааны тухайд өмнөх тайланд дурдсанчилан утас ээрэх машин хоцорч нийлүүлэгдсэнийг эс тооцвол зөв зохистой байсан гэж үзэж байна. Гэхдээ тэдгээрийн нийлүүлэгдсэн тоо хэмжээний тухайд дахин судалж үзмээр зүйл байна.

Мониторинг судалгааны үр дүнд доор дурдсан төхөөрөмжүүдийн ашиглалт бага, ажил эхлүүлснээс хойших хугацаанд хэрэгцээ багатай байсан байна гэж үзэхээр байна. Эдгээр төхөөрөмжүүд нийлүүлэгдсэнээр буцаан төлөх мөнгөний хэмжээ нэмэгдэж, улмаар буцаан төлөх хуваарьт өөрчлөлт оруулах нэгэн хүчин зүйл болсон байна.

Хонины ноос боловсруулах бүлгүүдэд ашиглалт багатай байгаа төхөөрөмжүүд

	Энхтуяа ахлагчтай бүлэг (Жижиг гар эдлэл үйлдвэрлэдэг)	Баянцагаан ахлагчтай бүлэг (Жижиг гар эдлэл үйлдвэрлэдэг)	Мөнхчимэг ахлагчтай бүлэг (Гэрийн эсгий үйлдвэрлэдэг)
Ашиглалт багатай төхөөрөмжүүд	Утас ээрэх машин, модон хэв (гэрийн шаахай, малгайны), ноосны сам (хэрэгцээтэй тооноос илүү олон тоогоор нийлүүлэгдсэн)	Ноос сэмлэгч машин	Эсгий гутлын төхөөрөмж
Шалтгаан	Утас ээрэх машин анх нийлүүлэгдэхдээ 3 дамартай байхаас ганц дамартай ирсэн. Бусад төхөөрөмжийн хувьд анх төлөвлөж байсан гишүүдийн тоо цөөрснөөс тооны хувьд илүүдсэн байдалтай байна.	Хонины ноосны чанар муу тул машинаар гэхээсээ гараараа ноосоо сэмлэхийг илүүд үздэг, машины гар эргүүлэхэд их хүнд байдаг, эд ангийн зарим хэсэг эвдэрснээс ашиглах боломжгүй байгаа.	Гэрийн эсгийний борлуулалт сайн байгаа тул эсгий гутал үйлдвэрлэх завгүй.

(4) Үр нөлөөлөл (Төсөөлөл)

Суманд шинэ ажлын байр бий болгож, иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд хувь нэмэр болж байна. Ноосыг сум дотроо төдийгүй зэргэлдээ сумын малчдаас худалдан авч байна. Эдгээр бүлгүүдийн боловсруулалт, борлуулалтын үйл ажиллагаа цаашид үргэлжлэн явагдвал ойр хавийн малчдын бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болох юм. Орон нутгийн эдийн засгийг бүхэлд нь идэвхижүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэг утгаараа өргөн хүрээнд үр нөлөөлөл үзүүлэх магадлалтай төсөл юм.

(5) Бие даан хөгжих чадвар (Төсөөлөл)

Гэрийн эсгий үйлдвэрлэх бүлгийн борлуулалт сайн байж, үйлдвэрлэл нь үргэлжлэн явагдвал борлуулалтын орлого нэмэгдэж цаашид бие даан хөгжих чадвар өндөр байна гэж үзэж байна. Гараар эсгий жижиг эдлэл хийж буй нөгөө 2 бүлгийн бүтээгдэхүүний борлуулалт одоогоор муу байгаа тул цаашид одоогийн байгаа борлуулалтын сүлжээгээ өргөтгөх, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдхүүн үйлдвэрлэх, борлуулалтын шинэ зах зээл, сүлжэг олох зэргээр борлуулалтыг бодитоогоор нэмэгдүүлэх хүчин чармайлт гаргах шаардлагатай.

2-7. Сургамж

- Эхний хөрөнгө оруулалтыг (хөнгөлөлттэй зээл) аль болох чухал шаардлагатай зүйлд л чиглүүлж, бусад хөрөнгө оруулалтыг бүлгийн үйл ажиллагаа тогтворжин гольдролдоо орсны дараа бүлэг бие даан шийдвэрлэж явах хэлбэрээр ажиллах зохимжтой.
- Технологи, үр чадвар эзэмшүүлэх сургалт зайлшгүй шаардлагатай. Технологи, менежмент, байгуулгын үйл ажиллагаатай холбоотой сургалт маш их ач холбогдолтой.

2-8. Дагалдах ажил

- Сумын ЗДТГ цаашид сум орон нутгийг хөгжүүлэх ажлын хүрээнд бүлгүүдийн үйл ажиллагаатай идэвхитэй холбогдож, асуудал бэрхшээлийг нь хамтран шийдэж явах хэлбэрээр ажиллах шаардлагатай байна.
- Сумын ЗДТГ буцаан төлөх хөрөнгө оруулалтын зардалын дүнд өөрчлөлт оруулах тухай санамж бичигт заасан хувиарын дагуу сумын худгийн санд хийгдэх буцаан төлөлт хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, мониторинг хийж, бүлгүүдэд зохих заавар, зөвлөмж өгч, дэмжин ажиллах шаардлагатай.

4.7.6 “Гар худгийн кампанит ажил” төслийн эцсийн шатны үнэлгээний тойм

1. Төслийн тойм

* Судалгаанд хамрагдах бүс нутаг: Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сум

* Хамрагдах бүлэг: Малчдын бүлэг

* Хэрэгжүүлэх байгууллага: Сумын ЗДТГ, малчдын бүлэг

1-1 . Хамтын ажиллагааны нөхцөл байдал ба тойм.

Гар худаг нь ашиглалт, хамгаалалтын зардал шаардагдахгүй, орон нутгийн мал аж ахуйг тэтгэдэг гол уст цэг юм. Гэвч ихэнх гар худгуудыг социализмын үед мэргэжлийн байгууллага гаргасан байдаг тул уламжлалт арга технологийг малчид бараг мартсан байна. Иймд сумын ЗДТГ гар худаг гаргах арга технологийг малчдад зааж өгч, шаардлагатай материал, багаж хэрэгслээр хангаж чадвал шинээр гар худаг гаргах, сэргээн засварлах ажилд ахиц гарах боломжтой юм. Тэрчлэн энэхүү судалгааны төслийн үр дүнд гар худаг гаргах, засварлах ажлыг урагшлуулах арга замыг тодорүүлж чадвал ХХАА Яамнаас зохион байгуулж буй гар худгийн кампанит ажилд хувь нэмэр болох юм.

1-2 . Хамтын ажиллагааны агуулга

(1) Зорилго

1) Төслийн зорилго

“Сумын ЗДТГ гар худгийн ажлын зохион байгуулах чадвартай болох”

2) Эрхэм зорилго

“Малчид ойр хавийн бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй хэмжээнд гар худаг гаргаж ашигладаг болно”

(2) Үр дүн

1) Гар худгийн багаж хэрэгсэл, материалыг захиран зарцуулах чадвартай болох.

2) Гар худаг гаргах ажлын зааварчилгаа өгөх мэдлэг, чадвартай болох

3) Гар худгийн ойр орчмын бэлчээрийн ашиглалтын талаар зааварчилгаа өгөх чадвартай болох.

(3) Хөрөнгө оруулалт (Үр нөлөөлөл)

Японы тал:

Гар худгийн мэргэжилтэн

Гар худаг гаргахад шаардлагатай багаж хэрэгсэл, материал нийлүүлэх (3 суманд нийт 1,600,000 иен : Сургалтанд шаарлагатай багаж хэрэгсэл, материал)

Сумын ЗДТГ

Сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, багийн засаг дарга, ЗДТГ-ын ХАА-н түшмэл, аж ахуйн нярав, төрийн сангийн төлөөлөгч ЗДТГ-ын агуулах, склад

Малчдын бүлэг:

Малчдын бүлгийн гишүүд, хүн хүч, материал (мод, цемент), багаж, хэрэгсэл

2. Үнэлгээний үр дүн

2-1. Үйл ажиллагааны ололтын шалгуур, нотолгоо

(1) Төслийн зорилго

Сумдад гар худгийн тоо нэмэгдсэн байна. Гэхдээ малчид гар худаг бол нийтийн өмч гэсэн ойлголттой байдгаас түүнд зарцуулах хөрөнгө мөнгийг хувиасаа гаргахыг сонирхохгүй байна. Өнөөгийн шатанд уг төслийн зохистой (оновчтой) байдал, үр дүнтэй байдлын үзүүлэлт өндөр байгаа боловч багаж хэрэгслийг түрээсээр олгох тал дээр зохистой (оновчтой) байдал, үр дүнтэй байдлын үзүүлэлт доогуур байна гэж дүгнэж байна. Малчдын хувийн зардалд тулгуурлахаас илүү сумын ЗДТГ-ын ажлын хүрээнд оруулах зэргээр засаж залруулах, төлөвлөгөөг үндсээр нь өөрчлөн сайжруулах шаардлага гарч ирж байна.

(2) Үр дүн

Үр дүн 1) Гар худгийн багаж хэрэгсэл, материалыг захиран зарцуулах чадвартай болох.

Одоогийн байдлаар багаж төхөөрөмжийн ашиглалт, хадгалалтын зүй зохистой тогтолцоо бүрдээгүй байна. Эрдэнэ, Улаанбадрах суманд багаж хэрэгслийн ашиглалт хамгаалалт харьцангуй сайн, Хөвсгөл суманд хангалтгүй байгаа тул сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай.

Үр дүн 2) Гар худаг гаргах ажлын зааварчилгаа өгөх мэдлэг, чадвартай болох

Төслийн хүрээнд хийсэн гар худаг гаргах ажлын гарын авлагыг сумын ЗДТГ-аас малчидад тараасан. Мөн гар худаг гаргах, засварлах ажлын сургалт явагдаж, сумын ЗДТГ-т энэ ажлын технологийг дамжуулсан. Гэвч гар худаг гаргахад ашигладаг багаж хэрэгслийг ашиглах хүсэлт гаргах малчид цөөн байна.

Үр дүн 3) Гар худгийн ойр орчмын бэлчээр ашиглалтын талаар зааварчилгаа өгөх чадвартай болох.

Энэ удаагийн кампанит ажлын хүрээнд гаргасан худгууд нь бүгд ашиглалттай бэлчээрт байгаагийн ихэнх нь өвөлжөө, хаваржаанд байна. Ерөнхийдээ бэлчээрийн усжуулалтын чадавхийг дээшлүүлэхэд нөлөөлсөн боловч зусланд гаргасан худгуудыг хэн ч ашиглаж болдог тул малын бөөгнөрөл үүсэж, бэлчээрийн байдалд нөлөөлсөн жишээ ч байна. Худаг гаргах газрыг урьдчилан судлах шаардлагатай.

2-2. Үнэлгээний үр дүнгийн тойм

(1) Оновчтой байдал (зүй зохистой байдал)

Өмнөх тайланд дурдсанчлан, Засгийн газрын чиглэл болох "Хүнс, ХАА-н талаар төрөөс баримтлах бодлого" (2003 он), "Усны Үндэсний Хөтөлбөр" (1999 он), Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2004-2008 он) зэргээс үзэхэд гар худаг гаргах, сэргээн засварлах ажил нь оновчтой байдлын үзүүлэлт нь өндөр ажил гэдэг нь батлагдаж байгаа юм. Мөн, ХХААЯ-наас гар худаг гаргах улсын уралдааныг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Эдгээр нөхцөл байдлаас үндэслэн уг төслөөр сумдын ЗДТГ-уудад гар худаг гаргах, сэргээн засварлах ажлын багаж хэрэгслийг нийлүүлсэн ба малчид эдгээр багаж хэрэгслийг ашиглан гар худаг гаргах ажлыг дэмжих зорилго тавьж байгаа тул зүй зохистой байдлын үзүүлэлт өндөр гэж хэлж болно.

Ашиглалт хамгаалалтын зардал шаардахгүй гар худаг нь малчдын амьдрал маш их ач холбогдолтой. Хэдийгээр гар худаг гаргадаг малчид байдаг боловч шаардлагатай хэмжээнд хүрдэггүй. Нэгдэлийн үед гар худгийн ажлыг мэргэжлийн байгууллага хариуцдаг байсан тул уламжлалт арга технологи нь малчид уламжлагдан үлдээгүй байна. Энэхүү арга технологийг сэргээж, малчдад эзэмшүүлэн, сумын ЗДТГ-т гар худаг гаргах ажлыг зохион байгуулах бүтцийг бий болгох зорилт тавьж байгаагаараа оновчтой байдлын үзүүлэлт нь өндөр гэж дүгнэж байна.

(2) Үр дүнтэй байдал

Уг төсөл хэрэгжсэний үр дүнд өнөөг хүртэл нийт 29 худгийн ажил хийгдэж, бодит ололт гарсаар байна. Энэ үр дүнгээс харахад төслийн үр дүнтэй байдлын үзүүлэлт өндөр байна гэж үзэхээр байна. Төсөл хэрэгжсэн 2 суманд гар худгийн зориулалттай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт сайн байна. 1 сумын хувьд цаашид үр дүнтэй ашиглаж явахын тулд багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, хяналтын тогтолцоо, зохион байгуулалтыг сумын ЗДТГ-т бий болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Мөн, төслийн зорилгыг биелүүлэхийн тулд хэрэглэсэн арга барилд ч асуудал байна. Анх малчид өөрсдийн санаачилгаар гар худаг гаргах, сэргээн засварлах бөгөөд тэдэнд худгийн ажилд шаардагдах багаж төхөөрөмжийг төлбөртэйгээр ашиглуулж байхаар төлөвлөсөн юм. Гэвч ихэнхи гар худгийг олон тооны малчид нийтээр ашигладаг тул хэн нэгэн малчин хөрөнгө мөнгийг хувиасаа гаргаж, нийтийн хэрэглээний гар худаг гаргах, сэргээн засварлах сонирхолгүй байгаа юм. Ийм учраас дээрх тооны 2/3 нь сумаас малчдыг уриалж, багаж төхөөрөмжийг үнэгүй ашиглуулж байж хийгдсэн худгийн ажлын тоо юм.

Тэрчлэн худгийн ажлын зааварчилга, зохион байгуулалтад төслийн хүрээнд явуулсан сургалтын үр дүнг нэвтрүүлээгүй, худгийн тоо нэмэгдсэн ч гаргаж буй худгийн чадавхи шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байгаа зэргээс үзэхэд төслийн үр дүн хангалттай сайн гэхэд учир дутагдалтай байна.

(3) Үр ашигтай байдал

2004 оны 5 сард төсөлд хамрагдах 3 сумдын ЗДТГ-т гар худгийн багаж төхөөрөмж (сургалт явуулах зардлыг оролцуулаад 1.6 сая орчим иений үнэ бүхий)-ийг нийлүүлж, төслийн ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд одоогоор нийт 29 худгийн ажил хийгдээд байна.

Үүнд: Сургалтын үеэр 6 (сум бүрд 2: шинээр гаргасан 2, сэргээн засварласан 4), малчид бие даан гаргасан 19 (шинээр гаргасан 4, сэргээн засварласан 23) худаг байна. Доорх хүснэгтэд төслөөр гаргасан, сэргээн засварласан гар худгуудыг харуулав.

Гар худаг гаргалт, сэргээн засварлалтын байдал

- 2004 оны 5 сар (төсөл эхэлсэн хугацаа)-аас 2005 оны 11 сар хүртэл -

Сумын нэр	Сургалтын үеэр гаргасан гар худгууд			Малчид бие даан гаргасан гар худгууд			Дүн
	Шинээр гаргасан	Зассан	Нийт	Шинээр гаргасан	Зассан	Нийт	
Эрдэнэ	0	2	2	2	7	9	11
Улаанбадрах	1	1	2	1	6	7	9
Хөвсгөл	1	1	2	1	6	7	9
Нийт	2	4	6	4	19	23	29

Нийлүүлсэн багаж хэрэгсэл, төхөөрөмжийн ашиглалт Эрдэнэ, Улаанбадрах суманд харьцангуй сайн, Хөвсгөл суманд хангалтгүй байна. Тэрчлэн ор сураггүй алга болсон багаж хэрэгсэлүүд нэлээд байна. Төсөөлж байсан үр дүн гарч байгаа боловч огт ашиглагддаггүй болон бага ашиглагддаг багаж хэрэгсэл нэлээн байгаагаас анхны хөрөнгө оруулалтын хэмжээг арай багасгаж болох байжээ гэсэн дүгнэлт хийж байна.

(4) Үр нөлөөлөл

Сумуудад гар худаг гаргахад ашиглах багаж хэрэгслийн нөөц бий болж, худаг гаргах, засварлах хүсэлтэй малчдад түрээсээр ашиглуулах замаар дэмжлэг үзүүлэх боломжтой боллоо. Ингэснээр гар худгийн ажлыг сумын ЗДТГ цаашид дэмжиж явах чиглэл тодорхой болж, орон нутгийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зохион байгуулалтыг бий болгоход эерэг нөлөөлөл үзүүлэв.

Гар худаг шинээр гаргасан газрын бэлчээрийг ашиглах боломжтой болж, хуучин худагтай байсан бэлчээрийн усжуулалтын үр ашиг нэмэгдэн, малын тарга тэвээрэг нэмэгдсэн. Худгийн орчим олон мал удаан хугацаагаар багшрахаа больсноор бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл багассан.

ХХААЯ, манай төслийн хүрээнд гаргасан гар худаг гаргах гарын авлага, зааварчилга дээр үндэслэн "Говийн бүсэд гар худаг гаргах ажлын зааварчилга" боловсруулж байгаа бөгөөд энэ ажил малчдад хүрч чадвал бүс нутгийн малчдад өргөн хүрээнд эерэг нөлөөлөл үзүүлэх болов уу.

(5) Бие даан хөгжих чадвар

Багаж хэрэгслийн тодорхой нөөцтэй болсноор сумын ЗДТГ гар худгийн ажлыг дэмжих боломжтой боллоо. Гэвч багаж хэрэгслийн нэгээхэн хэсгийг л хөлсөөр ашиглуулж байгаа нь багаж хэрэгслийг нөхөн авах, эвдэрсэн үед нь засвар үйлчилгээ хийхэд хөрөнгө мөнгөний хүндрэлд оруулах магадлалтай тул төслийн хувьд бие даан хөгжих нөхцөл бүрэлдээгүй гэж хэлж болно. Харин Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төслийн хүрээнд бий болгосон сумын худгийн санг гар худгийн ажилд үр бүтээлтэй ашиглаж чадвал эдийн засгийн хувьд бие даагаад явах нөхцөл бүрдэнэ гэж найдаж байна.

2-3. Үр дүн гарахад нөлөөлсөн хүчин зүйл

Сумын ЗДТГ—ын удирдан зохион байгуулах үйл ажиллагаа гар худгийн ажилд тодорхой амжилт гаргахад хувь нэмэр оруулсан. Эрсдэл өндөртэй шинэ худаг гаргахаас хуучин худгуудыг засварлан ашиглах асуудлыг чухалчлан үзсэн нь худгийн ажилд ахиц гаргах хүчин зүйл болсон байна.

2-4. Асуудал бэрхшээл ба асуудал бэрхшээл үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйл

(1) Төслийн агуулгатай холбоотой хүчин зүйл

Гар худгийн ажлын зориулалтаар нийлүүлсэн багаж хэрэгслийн зарим нь огт ашиглагдахгүй байна. Эдгээр нь малчдад байдаг буюу нийлүүлэх шаардлагагүй багаж хэрэгсэл байжээ.

Тэрчлэн, багаж хэрэгслийн ашиглалт, хамгаалалтын байдал тааруу байсан боловч сумын ЗДТГ-аас тодорхой хариуцах эзэнтэй болгох зэрэг хяналт, зохион байгуулалтын арга хэмжээ авч, байдлыг сайжруулсан.

(2) Хэрэгжилттэй холбоотой хүчин зүйл

Энэ төслийг төлөвлөхдөө малчид зардлаа хариуцаад идэвхи санаачлагатай оролцоно гэж тооцоолж байсан боловч малчдын санаачлагаар гар худаг гаргах ажилд ахиц гарсангүй. Гар худгийг хүн бүхэн үнэгүй ашиглаж ирсэн уламжлалтай бөгөөд худаг гаргасан хүн нь давуу эрхээр эзэмших юмуу бусдаас ашиглалтын хөлсийг хурааж авна гэсэн ойлголт байдаггүй. Өөрөө эзэмшиж чадахгүй юманд мөнгө зарах сонирхол байдаггүйгээс малчид худаг гаргахгүй байна. Иймд энэ төслийг цаашид орон нутгийн засаг захиргаа (сумын ЗДТГ) удирдан зохион байгуулж явах чиглэлтэй байна.

Гар худаг гаргах газрыг тогтоох арга технологи дутагдаж байсан бөгөөд энэ нөхцөл байдлыг сайжруулах зорилт анхнаасаа төслийн хүрээнд тавигдаагүй тул шинээр гар худаг гаргах ажилд ахиц гарсангүй. Малчид зардлаа хариуцах тохиолдолд, ус гарах магадлалтай гэж үзсэн газарт ч физик хайгуул хийх юмуу хуучин худгийн ором байгаа эсэхийг магадлан тогтоохгүй бол шинээр худаг гаргах ажил урагшлахгүй юм.

Тэрчлэн худгийн усжуулах чадавхийг дээшлүүлэхийн тулд ус гарсны дараа дахин сайтар ухаж, ус нөөцлөх зайг ихэсгэх хэрэгтэй. Ажлыг ийм хэмжээнд гүйцэтгэхийн тулд худаг ухах үед холбогдох хүмүүс шантаралгүй манлайлан ажиллах хэрэгтэй бөгөөд зардлын асуудлыг шийдсэн байх шаардлагатай юм. Энэ гольдролд оруулахын тулд гар худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлын сургалт явуулсан. Гэвч зардал хариуцсан малчин ус гармагц зардлаа хэмнэх үүднээс цааш нь үргэлжлүүлэн ухахаа больж байснаас худгийн усжуулах чадавхийг тэр болгон сайжруулж, сургалтын үр дүнг гаргаж чадахгүй байлаа.

2-5. Дүгнэлт

Анх багаж хэрэгслийг төлбөртэй ашиглуулахаар төлөвлөж байсан боловч сумуудын ЗДТГ төлбөртэй ашиглуулбал гар худгийн ажилд ахиц гарахгүй гэж үзэн төлбөргүй ашиглуулж эхэлснээр нийт худгийн ажлын 3- ны 2 нь хийгдсэн байна. Ер нь малчидад гар худгийн хэрэгцээ, шаардлага их байна. "Сумын ЗДТГ т шаардлагатай багаж хэрэгслийг олгож, арга технологийг нь эзэмшүүлбэл гар худгийн ажилд ахиц гарна" гэсэн бидний тооцоо зөвдсөн боловч "багаж хэрэгслийг төлбөртэй ашиглуулах" чиглэлээ эргэж харах шаардлагатай болсон юм.

Тэрчлэн шинэ худаг гаргах ажлыг урагшлуулахын тулд ус гарна гэсэн баталгаа байх нь тун чухал юм. Мөн худгийн усжуулах чадавхийг сайжруулахын тулд худгийн ажлыг удирдагч нь шантаралгүй, туйлбартай байж шаардлагатай хэмжээнд ухуулах нь чухлаас гадна худгийн ажлын арга технологийг өргөн нэвтрүүлэх, хөдөлмөр хөнгөвчлөх арга замуудыг эрэлхийлэх нь ихээхэн ач холбогдолтой юм.

2-6. Зөвлөмж

- Гар худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлыг урагшлуулахын тулд хамгийн наад зах нь сумуудад ус шавхах насос байх, гар худаг гаргах, засварлах ажлын зааварчлагыг боловсруулж өрх бүрт тараах шаардлагатай.

- Шинээр худаг гаргахын тулд уст цэгийн физикийн хайгуулыг явуулж, ус гарах боломжтой газрыг тогтоох шаардлагатай. Судалгаа хийхдээ "Бүх сумын ашиглалтгүй бэлчээрт гар худаг гаргаж болох 30 газрыг тогтооно" гэх мэт тодорхой тоогоор илэрхийлсэн зорилго тавин ажиллах нь чухал юм.

- Сумуудад Худгийн сан байгуулах асуудлыг төрийн бодлогод тусгаж, бүх суманд худгийн сан байгуулан гар худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлыг дэмжих шаардлагатай.

2-7. Сургамж

Зөвхөн малчдын санаачилга, хүч чармайлтад найдах нь учир дутагдалтай байна. Гар худаг гаргах, засварлах ажлыг орон нутгийн засаг захиргаа (сумын ЗДТГ) санаачлан зохион байгуулахаас гадна хамгийн наад захын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бааз суурийг бий болгох шаардлагатай. Мөн аймаг, улсын төсвөөс зохих хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг гаргаж байх шаардлагатай юм. Гар худаг гаргаж бэлчээрийн усжуулалтыг нэмэгдүүлэх нь бэлчээрийн ашиглалтыг сайжруулах үр дүнтэй арга байж болох боловч зусланд гаргасан худгийн орчимд олон мал бөөгнөрч бэлчээрт ачаалал өгөх явдал байдаг тул худаг гаргах газраа сонгохдоо үүнийг сайтар харгалзан үзэх шаардлагатай.

2-8. Дагалдах ажлууд

- Сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн багаж хэрэгсэл, төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтын байдал хангалтгүй байгаа тул Аймгийн ЗДТГ-ны зүгээс тодорхой хугацаанд мониторинг хийж байх нь зүйтэй юм.
- Энэхүү төслийн хүрээнд гаргасан гар худаг гаргах ажлын гарын авлага, зааварчлагыг үндэслэн ХХААЯ-наас боловсруулж буй "Говийн бүсэд гар худаг гаргах ажлын зааварчлагыг" өргөн хүрээнд тарааж, худгийн ажлын арга технологийг малчдад эзэмшүүлэх нь цаашид шинээр гаргах, сэргээн засварлах худгийн усжуулах чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.
- Малчдын хувьд гар худгийн хэрэгцээ шаардлага өндөр, гар худаг гаргахад шаардлагатай модон материалын дэмжлэг үзүүлэх хүсэлтийг их тавьдаг. Иймд Сумын худгийн сангийн хөрөнгийг ашиглан модон материалын нийлүүлэлтийг зохион байгуулах шаардлагатай. Үүний тулд Сумын худгийн сангийн үйл ажиллагаанд мониторинг хийж, гар худгийн ажилд үр бүтээлтэй ашиглахад чиглүүлэн удирдан зохион байгуулж явах нь чухал юм.

4.8 Туршилтын судалгааны хэрэгжилтийн үр дүнгээс олж авсан цаашдын төлөвлөгөөнд тусгууштай асуудлууд , тэдгээрийн нэгтгэсэн дүгнэлт

"Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төсөл"-ийн чиг хандлага ямар байвал зохихыг туршин үзэж, илүү үр дүнтэй хойшдын ажлын чиглэлийг гаргаж ирэхийн тулд 6 туршилтын судалгааны төсөл хэрэгжүүллээ. Эдгээр судалгааны төслүүдээр дамжуулан олсон мэдлэг, санаа оноог нэгтгэн дүгнэвэл, өмнөх хэсэгт дурдсан тус тусын төслүүдээс олж авсан цаашдын төлөвлөгөөнд тусгууштай асуудлуудаас гадна доор дурдах 3 асуудлыг мөн дараагийн төлөвлөгөөнд тусгах ёстой, чухал зүйл хэмээн үзлээ.

Хүснэгт 4.8.1 Туршилтын судалгаанаас цаашдын төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй хэмээн үзсэн асуудлууд

1. Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

- 1-1. Зохион байгуулалтад оруулах нь үр дүнтэй.
- 1-2. Үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулах, сан байгуулах нь үр дүнтэй.
- 1-3. Хэт их хөрөнгө оруулахгүй байхад анхаарах шаардлагатай.

2. Дүрэм, журам боловсруулахад анхаарах зүйлс

- 2-1. Дүрэм, журам боловсруулсны ач холбогдол гарч байх ёстой.
- 2-2. Дүрэм журам боловсруулсны ач холбогдол гарахгүй байвал яах вэ -Говийн нөхцөл дэх бэлчээрийн менежментийн дүрэм журам ямар байвал зохих -

3. Төслийн үр шимийг хүртэгчид болон засаг захиргаа (ялангуяа сумын ЗДТГ)-ны ажилтнуудыг сургах (хүний нөөцийн) сургалт

- 3-1. Засаг захиргааны ажилтнуудыг сургах
- 3-2. Төсөлд хамрагдагсдыг сургах
- 3-3. Малчдын бүлэг ба засаг захиргааны хооронд харилцан итгэлцлийн харьцааг бий болгох (Сумын ЗДТГ-аас явуулах хяналт-мониторингийн тогтолцоог бий болгох)

4.8.1 Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн төлөвлөгөө боловсруулах

(1) Малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулах нь үр дүнтэй.

Өргөн уудам тал нутаг дахь говийн бүсийн нүүдлийн МАА, малчдын амьдралын хэвшлийн дунд малчид хоорондоо холбоогүйгээр энд тэндгүй тарж нүүх, бүлэг байгуулсан ч гэсэн хамрагдах өрхийн нь тоо цөөрөх зэрэг сөрөг талууд байсан нь малчдыг зохион байгуулалтад оруулахын үр дүнтэй, бодит үр ашигтай байх тал дээр эргэлзээ төрүүлж байлаа.

Гэхдээ туршилтын судалгааны үр дүнд, говийн бүсэд ч гэсэн малчдыг зохион байгуулалтад оруулж, бүлгийн үйл ажиллагааг тогтвортой өрнүүлж болох юм гэдгийг баталлаа. Мөн ийнхүү зохион байгуулалтад орсноор малчид ба иргэд дор

дороо шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлуудыг бүлгийнхээ хэмжээнд өөрсдөө хэлэлцэж, хамтран шийдвэрлэж чадах юм байна, гэдэг далд чадвараа нээн гаргаж чадсан.

Үүгээр төслийн зорьсон үр дүн, тавьсан зорилтод хүрэхийн тулд малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулан үйл ажиллагаа явуулах ажлын үр дүнтэй гэдэг нь нотлогдож байна.

(2) Үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулах, сан байгуулах нь үр дүнтэй болно

Зохион байгуулалтад оруулахын зэрэгцээ бүлгүүдэд явуулж буй үйл ажиллагаандаа хандах эзэн хүний сэтгэлгээг төлөвшүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулахаар болсон. Зардал хариуцах нь тэдэнд эдийн засгийн ачаалал учруулах хэдий ч бүх бүлгүүд үүнийг зөвшөөрөн хүлээж авсан юм. Хариуцах зардлын буцаан төлөлтийн процесс төлөвлөгөөний дагуу биш ч гэсэн бодитойгоор явагдаж байгаа ба үр дүнтэй болох нь нотлогдож байна.

Иймд, цаашдын төлөвлөгөөний хэрэгжилтийн үед ч гэсэн тухайн үйл ажиллагааны үр шимийг хүртэгчдээр зардал хариуцуулж явахаар зайлшгүй тусгах нь зүйтэй.

(3) Хэт их хөрөнгө оруулалт хийхгүй байхад анхаарах шаардлагатай.

Үр шимийг хүртэгчдээр зардал хариуцуулахын хамтаар эхний удаагийн хөрөнгө оруулалтыг нэг удаад бөөнд нь хийж орхих юм бол (төсөлд) оролцогч энэхүү ачааллыг давж гарч чадахгүй байдалд орох магадлалтай. Иймээс эхний удаагийн тусламжийн хөрөнгө оруулалтын хэмжээг аль болох бага байлгаж, бүлгийн үйл ажиллагаа гольдролдоо орж, тодорхой хэмжээний туршлагатай болсон үед нь тэдний өөрсдийнх нь шийдвэрт үндэслэн шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг хийх нь зүйтэй.

4.8.2 Дүрэм, журам боловсруулахад анхаарах зүйлс

(1) Ач холбогдолтой дүрэм, журам

1) Сангийн үйл ажиллагааны журам

Уг туршилтын судалгааны аль ч төсөл дээр сан ажиллуулах нь тухайн үйл ажиллагааны гол тулгуур болж байлаа. Ингэж сан ажиллуулахад түүний үйл ажиллагааны дүрэм боловсруулж ажилласан явдал ач холбогдолтой болсон. Сум хөгжлийн сангийн хувьд урьд нь байгуулагдан ажиллаж байсан бол малжуулах сан, бэлчээр ашиглалт-худаг байгуулалтийн төслүүдийн хүрээнд байгуулсан сумын худгийн сан дээр түүний дүрмийг боловсруулан ашигласан нь ихээхэн ач холбогдлоо өгсөн. Сан, төслийн үр шимийг хүртэгчдийн буцаан

төлөх зардлын мөнгөнөөс бүрдэнэ. Зардал төлөгч талын хувьд сан зөв зохистой хяналтын доор ашигтай зарцуулагдаж байвал зардал төлөх сонирхлыг нь дэмжиж өгөх хүчин зүйл болох тул онцгой анхаарах шаардлагатай. Тиймийн тул тодорхой журмын дагуу, тодорхой шийдвэр гарган, сангийн үйл ажиллагааг явуулах нь түүний бүрэлдэн тогтноход зайлшгүй чухал юм.

Гэхдээ, сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгчид журмаа сайтар ойлгож, амьдрал дээр хэрэгжүүлэх явдал нь гол урьдчилсан нөхцөл мөн. Засаг захиргааны талын ажилтнууд өөрчлөгдөх тохиолдолд сангийн ажлыг чухалчлан үзэж, сайтар хүлээлгэн өгч авалцаж байх шаардлагатай.

2) Үйл ажиллагаа явуулах бүлэг ба засаг захиргааны хоорондын гэрээ

Судалгааны төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бүлэг ба засаг захиргаа (сумын ЗДТГ)-ны хооронд гэрээ байгуулсан. Уг гэрээнд үүрэг хариуцлагын асуудал ба хариуцах зардлын хэсгийг тодорхой тусган өгч, 2 талд алдаа мадагтай ойлголт төрүүлэхгүй байхаар зохицуулан, тус бүрд нь үүрэг хариуцуулсан. Энэхүү гэрээ нь эрх зүйн байр суурь тодорхойгүй малчдын бүлгийн хувьд цорын ганц тэднийг тодорхойлох зүйл болж байгаа ба зохион байгуулалтаа үргэлжлүүлэн авч явах тал дээр нь ч чухал үүрэгтэй.

(2) Ач холбогдолгүй журам -Говийн нөхцөл дэх бэлчээр ашиглалтын журам-

Говийн бүсийн цаг агаарын нөхцлөөс бэлчээрийн байдал харилцан адилгүй, жилийн агаарын температурын зөрөө ихтэй байдаг. Тухайн бүс нутгийн малчид нь бэлчээрийг уламжлалт аргаараа ашиглан, муутгахгүй байхад анхаарахын хамтаар илүү сайн бэлчээрийг байнга эрэлхийлэн нүүдэл хийж явдаг. Ийм орчинд худаг орчмын бэлчээрт бичгээр боловсруулсан бэлчээр ашиглалтын журам боловсруулан мөрдүүлж үзэхээр туршсан боловч малчид түүний ач холбогдол, шаардлагыг ойлгохгүй байгаа тул ийнхүү бэлчээр ашиглалтын журмыг зориуд бичгээр боловсруулах нь бодитоор хэрэгжих магадлал үгүй байна. Иймд бэлчээр ашиглалтын журмыг бичиглэн боловсруулахаас илүүтэй бэлчээрийн талаарх мэдээллийг захиргаа ба малчид харилцан мэдэж, хамтран ашиглах бэлчээрийн менежментийн тогтолцоог гаргаж ирэх ажлыг туршиж үзлээ.

4.8.3 Үр шимийг хүртэгчид болон засаг захиргаа (ялангуяа сумын ЗДТГ)-ны ажилтнуудыг сургах хүний нөөцийн сургалт

(1) Захиргааны ажилтнуудын сургалт

Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төсөл нь ихээхэн олон талыг хамарч буй төлөвлөгөө юм. Иймд энэхүү олон талт үйл ажиллагаанд оролцох захиргааны

ажилтнуудыг сургаж бэлтгэх нь зайлшгүй чухал ажил мөн. Төслийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн ажилд шаардагдах арга технологи төдийгүй, ялануяа биечлэн оролцох хэлбэр (төсөлд хамрагдагсад түүний бүх үе шатанд биечлэн оролцох хэлбэр)- ийг хөгжүүлэхэд шаардлагатай арга зам, иргэдийг зохион байгуулалтад оруулах арга замын талаарх чадварыг тэдэнд төлөвшүүлэх шаардлагатай. Үүнд, төслийн хэрэгжилтийн явцад чадвар төлөвшүүлэх ажлын байран дахь сургалтын арга чухал үр дүнтэй байдаг.

Үүнээс гадна багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт, сангийн хатуу хяналт, төслийн менежмент зэргийн талаарх сургалт, хүний нөөцийн сургалт шаардагдана.

(2) Үр шимийг хүртэгчид (малчид, иргэд)-ийн хүний нөөцийн сургалт

Малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зохион байгуулалтад оруулах төдийгөөр тогтвортой үйл ажиллагаа хадгалагдахгүй, үр шимийг хүртэгч малчид, иргэд шаардлагатай арга технологид суралцахгүй бол бүлгийн үйл ажиллагаа цаашид бие даан хөгжих ирээдүйгүй болно. Иймд тэдний дунд хүний нөөцийн болон технологийн сургалтыг явуулах зайлшгүй шаардлагатай. Үүнд, орон нутагт тухайн орон нутгийн хүний нөөц баялгийг ашиглан семинар сургалт явуулах, өмнө нь явагдаж ирсэн бусад үйл ажиллагааны туршлагыг тухайн газарт нь очиж судлах, текст материал тараах зэрэг янз бүрийн аргуудыг ашиглан хүний нөөцийн сургалтыг явуулах шаардлагатай.

(3) Малчдын бүлэг ба засаг захиргааны хооронд харилцан итгэлцлийн харьцааг бий болгох (Сумын ЗДТГ-аас явуулах хяналт-мониторингийн тогтолцоо бий болгох)

Төслийн хэрэгжилтийн явцад захиргааны байгууллага бүх бүлгүүдийн ажилд хийх мониторингийн ажлыг хязгаарлагдмал тээврийн хэрэгсэл, цаг хугацаа, ажилтнуудын хүчээр ч гэсэн хэр чинээгээрээ амжуулан хэрэгжүүлж, асуудлыг урьдчилан сайтар ойлгож, хэрэгцээт зөвлөгөө, тусламжийг үзүүлж байх шаардлагатай. Басхүү, бие даан хөгжих суурь үндэс байвал түүнийг загвар болгон улам өргөн цар хүрээтэй үр дүн гаргахыг зорьж, идэвхитэйгээр цаашдын үйл ажиллагаанд хөтлөн оруулж байх хэрэгтэй.

Үүнээс гадна, хяналт-мониторингоор дамжуулан малчидтай санаа оноогоо нийлүүлэх боломж ихсэж, харилцан ойлголцол гүнзгийрэх ба төслийг саадгүй удирдан явуулах боломжтой болно. Малчидтай шууд нүүр тулан харилцдаг сумын ЗДТГ-ын үүрэг роль ихээхэн чухал бөгөөд сумын ЗДТГ-т хандсан хүний нөөцийн сургалтын тусламж шаардлагатай юм.

**БҮЛЭГ 5 Мал аж ахуйн тогтолцоог
сайжруулах төлөвлөгөө**

Бүлэг 5 Мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөө

5.1 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг, төсөл

3-р бүлгийн "Хөгжлийн чиглэл" гэсэн хэсэгт Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой "Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент", "МАН-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах", "Малчин өрхийн орлогыг тогтворжуулах" гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүн хэсэг болон эдгээрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах "Хүний нөөцийг хөгжүүлэх" гэсэн бүрэлдэхүүн хэсгийн тухай өгүүлсэн билээ. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг 5.1.1 дүгээр хүснэгтэд харуулав. Энэ бүлэгт, 4-р бүлэгт дурьдсан туршилтын төслийн үр дүнгээс олж авсан мэдлэг, туршлагыг тусгах хэлбэрээр Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд болон холбогдох төслүүдийн талаар өгүүлэх болно.

Хүснэгт 5.1.1 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд ба төслүүд

Бодлого/эцсийн үр дүн	Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөл
Хөдөөгийн МАН-н тогтолцоог сайжруулах (Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхагдлыг арилгах)	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент
	Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах	Мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах
		Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх
		Мал маллагааны арга, технологийг сайжруулах
	Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх	
Малчин өрхийн орлогыг тогтворжуулах	Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах	
Хүний нөөцийг хөгжүүлэх	Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах	
	Хүний нөөцийг хөгжүүлэх /төсөл бүрээр/	

5.2 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн бүрэлдэхүүн хэсэг

Нүүдлийн мал аж ахуйн системийн суурь дэвсгэр болсон бэлчээр, усны аль нэг нь байхгүй бол нүүдлийн мал аж ахуй оршин тогтнох нөхцөлгүй юм. Өнөө үед тэдгээрийн байршил, ашиглалтын тэнцвэр алдагдсан нь улирлын чанартай отор, нүүдэл хийхэд саад учруулж буй нэгэн хүчин зүйл болж байна.

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн асуудал нь бэлчээрийн нөөц баялгийг аль болох үр дүнтэй ашиглахад чиглэх бөгөөд бие биенээс нь салгалгүй нэгэн цогц байдлаар авч үзэх ёстой юм. Иймд энэ бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх төсөл нь "Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төсөл" байх юм.

(1) Төслийн ерөнхий агуулга

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр урьд нэгдэл хариуцан хэрэгжүүлж байсан худгийн ашиглалт, хамгаалалт, бэлчээр ашиглалтын асуудлыг малчид өөрсдөө шууд хариуцах болов. Гэвч зах зээлд шилжих үед худгийн ашиглалт,

хамгаалалтын талаархи хариуцлагын тогтолцоог ямар нэгэн хэлбэрээр тодорхой байлгаж чадаагүйн улмаас худгийн ашиглалт удаан үргэлжлэх боломжгүй болж, ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийн талбай нэмэгдэн, зун, намрын отор нүүдэл зогсохын зэрэгцээ, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг жилийн турш хэтрүүлэн ашигласнаар бэлчээрийн талхлагдал эрчимтэй явагдахад хүрсэн байна.

Ийм нөхцөл байдалд засаг захиргааны зүгээс худаг байгуулалтын ажлын үр ашгийг дээшлүүлэх замаар бэлчээр ашиглалтыг хязгаарлаж буй хүчин зүйлүүдийн нөлөөллийг арилгаж бүс нутгийн хэмжээнд бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх урьдчилсан нөхцлийг хангахын хамт малчид гол цөм нь болон хэрэгжүүлэх бэлчээрийн зүй зохистой ашиглалт, худгийн ашиглалт хамгаалалтыг тогтвортой үргэлжлүүлэн явуулахад шаардлагатай арга хэмжээг авч явуулахаар болсон юм.

(2) Хамрагдах бүлэг ба хэрэгжүүлэх байгууллага

Хамрагдах бүлэг : Малчдын бүлэг, Хэрэгжүүлэх байгуулга : ХХААЯ, аймгийн ХХАА-н газар, сумын ЗДТГ

(3) Зорилго

1) Төслийн зорилго

Бэлчээрийн тогтвортой ашиглалтын тогтолцоо бий болно.

2) Эрхэм зорилго

Бэлчээрийн даац сайжирах үйл явц үргэлжлэн явагдсанаар бэлчээрийг тогтвортой ашиглах боломжтой болно.

(4) Үр дүн

Энэхүү төслийн хүрээнд бүс нутгийн бэлчээрийг зүй зохистой ашиглахад чиглэсэн үйл ажиллагаа, түүний урьдчилсан нөхцөл болох худаг байгуулалт, худгийн ашиглалт, хамгаалалт, бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бүх төрлийн арга хэмжээг авч явуулан, "Бэлчээр ашиглалтын арга хэлбэрийг сайжруулах", "Худаг байгуулах", "Худгийн тогтвортой ашиглалтыг хангах" зорилтыг тавьж байна.

1) Бэлчээр ашиглалтын арга хэлбэр сайжирна.

Бэлчээрийн менежментийг бүс нутгийн малчид гол цөм нь болон хэрэгжүүлэх бөгөөд энэ талаархи малчдын ойлголтыг гүнзгийрүүлэн, бие даасан санаачлагатай үйл ажиллагааг нь хөхүүлэн дэмжих шаардлагатай юм. Сумын ЗДТГ нь бэлчээрийн нөөц, үйлдвэрлэл, ашиглалтын аль алиныг нь хамарсан "Бэлчээрийн мониторингийн тогтолцоог" бий болгож, малчдад зориулсан сургалт явуулах, мэдээлэл олгох зэргээр бүс нутгийн бэлчээрийг зүй зохистой ашиглахад чиглэсэн үйл ажиллагааг санаачлан зохион байгуулна.

2) Худаг байгуулалтын ажил тодорхой төвшинд хэрэгжинэ.

Бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг хангахын тулд "уст цэгийн хомсдол" зэрэг бэлчээр ашиглалтыг хязгаарлах хүчин зүйлүүдийг арилгаж, бэлчээрийг тохиромжтой цаг үед нь зохицуулан ашиглах нөхцлийг бий болгох шаардлагатай. Иймд Засаг захиргаа худаг байгуулалтын ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.

3) Худгийн арчилгаа, хамгаалалтын ажил тогтвортой үргэлжлэн явагдана.

Худгийн арчилгаа, хамгаалалтын ажлыг ашиглагч болох малчид хариуцах бөгөөд худгаа бэлчээр ашиглалттай уялдуулан тогтвортой ашиглаж явах шаардлагатай. Иймд малчдын худагтаа хандах эзэн хүний сэтгэл зүй, ухамсрыг дээшлүүлэхийн хамт сум, аймгийн ЗДТГ-аас үзүүлэх дэмжлэгийн тогтолцоог бий болгоно.

(5) Хөрөнгө оруулалт

Бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох (оношлогоо хийх), бэлчээрийн мониторингийн сургалт, худаг байгуулалтын ажил, худгийн арчилгаа, хамгаалалтын талаархи сургалт, сумын хэмжээнд худаг байгуулалт, засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох(бүлэг болон нэгдэх үйл ажиллагааг дэмжих хөрөнгө, сумын худгийн сан, худгийн тоног төхөөрөмжийн засварчны сургалт)

5.2.1 Төлөвлөгөө боловсруулахтай холбоотой үзэл баримтлал

(1) Газар зүйн мэдээллийн системийг (ГМС) ашигласан тухайд


Төслийн хүрээнд Газар зүйн мэдээллийн системийг үр дүнтэй ашиглах замаар худаг болон бэлчээрийн даацын мэдээллийг нэгтгэн авч үзэж, бүс нутгийн байдлыг сайтар тодруулсны үндсэн дээр төлөвлөгөө боловсруулав.

Худаг байгуулалтын талаарх мэдээллийг 1991 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд бүрдүүлсэн геоэкологийн хүрээлэнгийн мэдээллийн сангаас авч ашигласан. Ингэхдээ Дорноговь аймгийн ЗДТГ, ХХАА-н газраас авсан мэдээллүүдтэй тулгах, судалгааны явцад тодруулах зэргээр өөрчлөн шинэчилсэн болно. Газрын гадарга, гол горхи, булаг шанд, нуур цөөрмийн талаарх мэдээллийн хувьд 1:500,000-ын масштабтай байр зүйн зураг тулгуурлан боловсруулсан ГМС мэдээллийг ашигласан болно.

Бэлчээрийн даацын судалгааны ажилд "Монгол орны бэлчээрийн чадавхи, экологийн орчин ба чанарын үнэлгээ" номны мэдээллийг авч ашиглав (Мал аж ахуйн хүрээлэн 2000 он. Д.Цэрэндаш).

(2) Тогтвортой усжуулалттай бэлчээрийг тогтоосон нь

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын ажлын гол үзүүлэлт болох усжуулалтын чиглэлийг гаргаж ирэхийн тулд усжуулалтын одоогийн хувь хэмжээг тогтоох нь чухал. Иймд уст цэгээс 5 км хүртэл радиустай тойргийг уст цэгтэй,



Зураг 5.2.1 Тогтвортой уст цэг

ашиглах боломжтой, тогтвортой усжуулагдсан бэлчээр (5км-ийн радиустай тойрог) гэж авч үзэхээр болов. Тэрчлэн энэхүү тогтвортой усжуулагдсан бэлчээрийг дотор нь 3 км-ийн радиустай бог мал бэлчээх тогтвортой усжуулагдсан бэлчээр (3км-ийн радиустай тойрог), бод мал бэлчээх тогтвортой усжуулагдсан бэлчээр (3-5км-ийн радиустай тойрог) гэж зааглан тогтоож байна.

(3) Төлөвлөгөөнд тусгагдаж буй бэлчээрийн даац, тогтвортой усжуулагдсан бэлчээрийн хоорондын харилцан хамаарал

Тогтвортой усжуулалттай бэлчээрийн (5км-ийн радиустай тойрог) уст цэг рүү ойртох тусам бэлчээр ашиглалтын нягтрал ихэсдэг. Тооцоог хялбар болгох үүднээс бод мал (3-5 км-ийн радиустай) тойргийг ашиглана гэж үзсэн боловч бодит байдал дээр 3 км-ийн радиустай тойргийн бэлчээрийг ч ашиглаж байна. Иймэрхүү бэлчээр ашиглалтын бодит байдлыг сайтар харгалзан, бэлчээрийн даацыг тооцоолон гаргаж төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.

Ингээд Дорноговь аймгийн хэмжээний тогтвортой усжуулалттай 3 ба 5 км-ийн радиустай тойргийн бэлчээрийн талбайн харьцаа болон бог, бод малын тоон харьцааг ашиглан тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай бэлчээрийн ашиглалтын төвшинг 1 гэж үзээд (3-5 км-ийн радиустай тойргийн) бэлчээрийн ашиглалтын төвшинг тооцоолоход 0.56 болж байна.

Эндээс тогтвортой усжуулалттай (3-5 км-ийн радиустай тойргийн) бэлчээрийн даацын дөнгөж 60 хувийг ашиглах боломжтой гэж төлөвлөгөөнд тусгав. Цаашид бод малын тоо өсч, бүс нутгийн малын бүтцэд өөрчлөлт гарвал энэ хувь хэмжээг нэмэгдүүлж, тогтвортой усжуулалттай (3-5 км-ийн радиустай тойргийн) бэлчээрийн ашиглалтын төвшинг дахин судалж үзэх шаардлагатай.

**Хүснэгт 5.2.1 Тогтвортой усжуулалттай бэлчээрийн ашиглалтын төвшин
(Дорноговь)**

	Тогтвортой усжуулалттай бэлчээр(3 км-ийн радиустай тойрог)	Тогтвортой усжуулалттай бэлчээр (3-5 км-ийн радиустай тойрог)
Бэлчээрийн даац	1,400,277	965,301
2002 оны малын тоо, толгой	1,039,665	403,680
Бэлчээрийн даац ба малын тооны харьцаа	74%	42%
Бэлчээрийн даацын ашиглалтын төвшин (Тогтвортой усжуулалттай 3км-ийн радиустай бэлчээрийг 1 гэж авав.)	1	0.56

(4) Усжуулалтын чадавхийн ялгаанаас хамааруулан бэлчээр ашиглалтын төвшинг тогтоосон нь

Худгийн усжуулах чадавхийн ялгаанаас хамааран мал усалгааны үр ашиг өөр өөр байна.

Усжуулалтын үр ашиг нь тухайн худгийн чадавхи, ойр хавийн малын тоо, толгой, бэлчээрийн нөөцөөс хамааран өөр өөр байх бөгөөд үүнээс бэлчээр ашиглалтын төвшин шууд шалтгаалах юм. Усжуулалтын үр ашгийг тооцоолон гаргахдаа худгийн ойр орчмын бэлчээр ашиглалтын төвшин нь өрөмдмөл худгийн хувьд 1, гар ажиллагаатай уурхайн худгийн хувьд 0.9, гар худгийн хувьд 0.8, булаг шандны хувьд 0.7 байна гэж таамаглаад бэлчээрийн даацыг нь тооцож үзлээ.

Хүснэгт 5.2.2 Уст цэгийн төрөл болон бэлчээр ашиглалтын төвшинг тогтоох

Уст цэгийн төрөл	Өрөмдмөл худаг, богино яндант худаг, сэргээн засварласан уурхайн худаг, тогтоол ус	Гар ажиллагаатай уурхайн худаг	Гар худаг	Булаг шанд
Бэлчээр ашиглалтын төвшин	1	0.9	0.8	0.7

(5) Төлөвлөгөөнд тусгай хамгаалалттай газрын бэлчээрийн ашиглалтын асуудлыг тусгасан нь

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн тусгай хамгаалалттай газрыг мал аж ахуйд ашиглахыг зарчмын хувьд хориглодог боловч бодит байдал дээр ашиглагдсаар байгаа юм. Иймд тусгай хамгаалалттай газрыг цаашид ч одоогийн байдлаар ашигласаар байх боловч шинээр бэлчээр эзэмшиж, талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх нөхцлөөр авч үзлээ. Эндээс төлөвлөгөөнд хамрагдах бэлчээрийн нийт талбайн хэмжээг 3 аймгийн нутаг дэвсгэрээс тусгай хамгаалалттай газрын талбайг хасаад гарсан талбай дээр одоогоор ашиглагдаж буй тусгай хамгаалалттай газрын тогтвортой усжуулалттай бэлчээрийн (5км-ийн радиустай тойрог) талбайг нэмсэн талбай байхаар тооцлоо. Мөн бэлчээрийн даацыг ч үүнтэй нэгэн адил аргачлалаар тооцон гаргав.

(6) Худаг байгуулалтын төлөвлөгөөний үзэл баримтлал

Судалгаанд хамрагдсан 3 аймгийн бэлчээрийн нөхцөл байдлыг сайтар харгалзан үзсэний үндсэн дээр бүс нутгийн бэлчээрийн даацыг үр дүнтэй ашиглахад чиглэсэн ирээдүйд хэрэгжүүлэх худаг байгуулалтын мастер төлөвлөгөөг боловсруулав. Үүн дотроо, дахин ашиглах бүрэн магадлалтай хуучин худгийг засварлах, оронд нь худаг гаргах зэргээр урьд хийгдсэн физик хайгуулын үр дүнгээс үзэхэд уст цэг болгон ашиглаж болохуйц байгаа газруудад нэн тэргүүний ээлжинд хэрэгжүүлэх худаг байгуулалтын 1-р үе шатны төлөвлөгөөг боловсруулсан болно.

5.2.2 Бэлчээрийн ашиглалт, менежмент

(1) Бэлчээрийн ашиглалт, менежментийн бодлого

Бэлчээрийн ашиглалт, менежментийн төлөвлөгөөнд бэлчээр, усны нөөцийн ашиглалт, байршлын тэнцвэргүйдлийг залруулах асуудал нэн тэргүүний зорилт болон тавигдах юм. Энэ тохиолдолд бэлчээрийн ядмагхан нөөцөөр хязгаарлагдсан говийн нөхцөлд улирлын чанартай отор, нүүдлийг хөхүүлэн дэмжих асуудлыг үндсэн чиг баримтлал болгон авч үзнэ.

Нүүдлийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд бэлчээрийн даацыг хадгалж, тогтворжуулах нь чухал ач холбогдолтой юм. Бэлчээрийн даацыг хадгалах, тогтворжуулах, улмаар сайжруулах талаар дор дурьдсан 4 төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:


- #1 Малын тоо толгойг хэт өсгөхөөс сэргийлж, бэлчээрт өгөх ачааллыг багасгах (Нийтээр мөрдөх дүрэм, журам)
- #2 Тэжээлийн ургамлыг тариалж газрын үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх (Эрчимтэй ашиглах)
- #3 Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг усжуулж, тэдгээрийн ашиглалтыг тогтворжуулах (Худаг байгуулалт)
- #4 Улирлын чанартай отор нүүдэл, усжуулалтын зүй зохистой арга хэлбэр зэрэг бэлчээр ашиглалтыг сайжруулахад чиглэсэн арга замуудыг эрэлхийлэх (Усжуулалтын менежмент, бэлчээрийн менежмент)

Гэвч малын тоо, толгойн өсөлтийг хязгаарлах нь бараг боломжгүй асуудал юм. Тэрчлэн говийн нөхцөлд ихээхэн хэмжээний тэжээлийн ургамал тариалах нь хүндрэлтэй, усжуулах систем нэвтрүүлээ ч зардлаа нөхөх боломжгүй юм. Мөн хөрсний давсжилт зэрэг байгаль орчны асуудлуудыг судалж үзэх шаардлагатай болно.

Иймд энэхүү төлөвлөгөөний хүрээнд бэлчээр ашиглалт, бэлчээрийн менежментийг сайжруулахад чиглэсэн хамгийн зохимжтой арга хэмжээ байж болох #3-д дурьдсан ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг усжуулж,

тэдгээрийн ашиглалтыг тогтворжуулах (материаллаг тал) болон #4-д дурьдсан Бэлчээрийн ашиглалтад хийх мониторингийн үр чадварыг дээшлүүлэх, сайжруулах (Оюунлаг тал) арга хэмжээг уялдаа холбоотой хослуулан хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Дээр дурьдсан бэлчээрийн ашиглалт, менежментийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнд бэлчээрийн тогтвортой ашиглалтын тогтолцоо бий болж, бэлчээрийн даацыг тогтвортой сайжруулах, улмаар нэмэгдүүлэх боломжтой болно. Бэлчээрийн ашиглалт, менежментийн хамрах хүрээг дараахь зурагт харуулав.



Зураг 5.2.2 Бэлчээр ашиглалт, менежментийн үйл ажиллагаа

Бэлчээрийн ашиглалт, менежментийн арга хэмжээний хүрээнд “Бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгох”, “Өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах”, “ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрт усжуулах байгууламж бий болгох” гэсэн гол, гол үйл ажиллагааг уялдаа холбоотойгоор хослуулан хэрэгжүүлнэ.

(2) Бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгох

Бэлчээрийн мониторингийг хийхэд сумын ЗДТГ голлох үүрэг гүйцэтгэнэ. Мониторингийн үндсэн үйл ажиллагаа нь бэлчээрийн нөөцийн мониторинг, бэлчээрийн ашиглалтын мониторинг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

1) Бэлчээрийн нөөцийн мониторинг


Бэлчээрийн хэмжилтийг Ус цаг уурын албаны орон нутаг дахь салбар хариуцан хийдэг боловч ажиглалтын цэг нь хязгаарлагдмлаас гадна малчдад шууд үр дүнтэй ашиглаж болох мэдээлэл болж очдоггүй зэрэг бэрхшээл байдаг. Иймд зохих арга, технологийг ашиглан, малчидтай хамтран хялбар хэмжилт, тооцооллыг хийх хамтын ажиллагаан дээр үндэслэсэн бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг Сумын ЗДТГ санаачлан зохион байгуулна. 5.2.3 дугаар хүснэгтэд Сумын ЗДТГ ба малчдын хамтран хэрэгжүүлэх бэлчээрийн

төлөв байдлыг тодорхойлох ажлын онцлогийг Ус цаг уурын албаны орон нутаг дахь салбарын хэмжилтийн аргатай харьцуулан харуулав.

Хүснэгт 5.2.3 Бэлчээрийн хэмжилтийн 2 аргын харьцуулалт

	Малчид-Сумын ЗДТГ-ын хамтын хүчээр бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох	Ус цаг уурын албаны ажиглалт
Зорилго	Өвөлжөө/ хаваржааны бэлчээрийн байдлын мэдээллийг өгөх	Өвөлжилтийн бэлтгэл хангах, өвс тэжээл бэлтгэх ажлыг зохин байгуулахад нь зориулан орон нутгийн Засаг захиргааг мэдээллэр хангах
Хэнд зориулсан мэдээлэл болох	Малчид	Орон нутгийн засаг захиргаа ба малчид, гэхдээ ОНЗЗ-нд ихэвчлэн зориулагддаг.
Хэмжилтийн арга	Ургамлын өндөр (Н) ба ургамлан бүрхэцийн хувь хэмжээ (С)-нээс бэлчээрийн чадавхийн таамаг тооцоо хийх	Хуурай үеийн жин (DMW)-г хэмжих
Хэмжилт хийх цаг үе	Жил бүрийн 8-9 сар	Жил бүрийн 7-8 сар
Мэдээллийг олгох цаг үе	Жил бүийн 10-11 сар	Жил бүрийн 9 сар
Мэдээллийн нарийвчлал, мэргэжлийн түвшин	Харьцангуй доогуур түвшин, сургалтанд хамрагдах шаардлагатай	Харьцангуй өндөр түвшин, мэргэжлийн сургалтанд хамрагдсан байдаг
Ажиглалтын цэгийн тоо	Олон (Энэ жил 30 цэгт хийсэн)	Цөөн (Сумын төвийн ойролцоо 10 цэг)
Ажиглалт хийх газар	Сумын хэмжээнд тархуу байрладаг	Голдуу сумын төвийн ойролцоо

Малчид болон Сумын ЗДТГ хамтын хүчээр бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ажлын агуулга, хэрэгжүүлэх дарааллыг дараахь зурагт харуулав.



Зураг 5.2.3 Бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ажлын тойм

Малчдаас хэмжилтийн тэмдэглэлийг цуглуулан авч сумын ЗДТГ-т хүргэх, эдгээр үзүүлэлт дээр үндэслэн ЗДТГ-ын хийсэн тооцоог малчдад буцаан хүргэх ажлыг багийн дарга хариуцна. Мөн багийн дарга малчдад хэмжилтийн хялбар аргыг зааж сургах үүрэгтэй. Иймд багийн дарга нар болон малчдыг сургалтанд хамруулж байх шаардлагатай болно. Сургалтыг сумын ЗДТГ-т явуулж болох бөгөөд сумын ЗДТГ-ын ХАА хариуцсан түшмэл, багийн дарга малчдаас цуглуулж ирсэн хэмжилтийн үзүүлэлтийг нэгтгэн тооцоолж, бэлчээрийн даацын мэдээллийг малчдад тараана. Тэрчлэн сумын ЗДТГ бэлчээрийн даацын тооцооны үр дүнг сумын хэмжээнд тархсан өвөлжөө, хаваржааны бэлчээрийн олон жилийн өөрчлөлтийн үзүүлэлт, мэдээллийн хэлбэрээр хадгална.

2) Бэлчээрийн ашиглалтын мониторинг

Бэлчээрийн нөөцөөс гадна бэлчээрийн ашиглалтад байнга мониторинг хийх тогтолцоог бий болгоно. Ялангуяа хойно өгүүлэх Худаг байгуулалтын төлөвлөгөөтэй холбоотойгоор малчдын улирлын чанартай отор нүүдэл, уст цэг хослуулан ашиглах байдлыг мониторинг хийх замаар бүрэн тодруулна.

Сумын ЗДТГ малчдаас дараах 2 төрлийн үндсэн мэдээллийг цуглуулан авна.

- Малчин өрхүүдийн малын тоо, толгой
- Малчин өрхүүдийн сар тутам ашиглаж буй уст цэг (жилийн турш хийх нүүдлийн тэмдэглэл)

Үүний дараа тодорхой хугацаан дахь тухайн нэгэн уст цэгийн ашиглалтын давтамжийг тоогоор илэрхийлж, малын тоо, толгойн үзүүлэлт дээр үндэслэн тухайн уст цэгээсээ хамаарах төвшинг тооцоолон гаргана. Уст цэг (худаг)-ээс хамаарах төвшинг тогтоосноор тодорхой уст цэгийн орчимд төвлөрөх малын тоо, толгой, улирал, цаг хугацааны баримжааг авч болно. Говийн бүсэд улирлын чанартай нүүдэл хийх явцад 1 өрх жилийн турш 3-4 худаг болон нуур ашигладаг бөгөөд энэхүү бэлчээрийн даацад тохирсон зүй зохистой ашиглалтыг бий болгоход чиглэсэн мониторингийн үзүүлэлтийг үр дүнтэй ашиглах боломжтой. Бэлчээрийн ашиглалтад хийх мониторингод нь бэлчээрийн нөөцийн мониторинг хийхэд хэрэгжүүлдэг бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг хавсран хэрэгжүүлснээр бэлчээрийн даацыг сайжруулах, нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах юм.

3) Малын тоо толгойн зохистой хэмжээ, ашиглалтын балансыг тогтооход шаардлагатай үзүүлэлт

i) Тухайн орчныг нь харгалзан тогтоох малын тоо толгойн зохистой хэмжээ

Энэ төслийн хүрээнд МАА-н хүрээлэнгийн бэлчээрийн даацын (Цэрэндаш, бусад. 2000) тооцооны үзүүлэлт дээр үндэслэн сүүлийн жилүүдийн цаг уурын өөрчлөлтийг харгалзан тухайн орчныг харгалзан үзсэн (тухайн орчинд байвал зохих) малын тоо толгойн тохиромжтой хэмжээг аюулгүйн коэффициент 0.9-өөр үржин тооцоолов.

Хүснэгт 5.2.4 Малын тоо толгойн зохистой хэмжээ (аймаг тус бүрээр)

		Ургац (кг/га)	Малын тоо (х.т./км ²)	1хүдгийг ашиглаж болох малын тоо (х.т.)*
Дундговь	Хойд**	285.6	50.1	1416
	Өмнөд	155.1	33.0	933
	Дундаж	197.9	42.1	1190
Дорноговь	Зүүн хойд	150.7	32.1	906
	Зүүн урд	147.1	31.3	885
	Дундаж	149.5	31.8	899
Өмнөговь	Хойд	122.2	26.0	735
	Өмнөд	89.8	19.1	540
	Дундаж	106.2	22.6	639

Санамж : *1хүдгийн бэлчээрийн талбайг тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай тойргоор авав.

**1 жилд шаардагдах тэжээлийн хэмжээг 470кг /хонины оронд 570кг/ х.т.-оор авав.

*х.т.= Хонин толгой : 1 хонинд ноогдох бэлчээрийн даац

1 худагт ноогдох малын тоо нь тогтвортой усжуулагдсан 3 км-ийн радиустай тойрогт жилийн турш идээшлүүлж болох малын тоо толгойн баримжаа үзүүлэлт юм. Малчид өөр бэлчээр, уст цэг рүү нүүдэл хийж жилийн турш хэд хэдэн уст цэгийг хослуулан ашигладаг тул бэлчээр ашиглалтын бодит байдлыг тогтоох нь бэрхшээлтэй байдаг. Гэвч бэлчээрийн оношлогоо хийх замаар бэлчээрийн нөөц, малын тоо толгойг тогтоох, уст цэг ашиглалт, нүүдлийн тэмдэглэл дээр үндэслэсэн ажиглалт, тэмдэглэл хийх зэрэг ажлыг тогтвортой үргэлжлүүлэн явбал 1 жилийн турш улирлын чанартай уст цэгийн ашиглалтын байдал ямар байхыг хангалттай тодруулж болно. Сумын ЗДТГ бэлчээрийн мониторингийн үндсэн мэдээллийг ашиглан худаг ашиглалтаас хамаарах төвшинг (1хүдгийг улирал бүрд ашиглах малын тоо) тооцоолон гаргана. Тэрчлэн үүнийг тухайн хүдгийг ашиглаж болох малын тоо толгойн зохистой хэмжээтэй харьцуулахад бэлчээрийн менежментийн баримжаа үзүүлэлт болгон ашиглана.

ii) Уст цэгийн ойр орчмын бэлчээрийн талхлагдлыг багасгах ба 3-5км-ийн хүрээг үр дүнтэй ашиглах

Уст цэгээс 3 км-ийн доторхи тогтвортой усжуулагдсан бэлчээр (3км-ийн радиустай тойрог), 5 км-ийн радиустай тойргийн тогтвортой усжуулагдсан

бэлчээрийг тогтоохтой уялдуулан Дорноговь аймгийн нийт усжуулагдсан бэлчээрийн давхардлыг харгалзан үзэж ноогдох малын тоог дараахь байдлаар тооцоолсон болно.

1. Тогтвортой усжуулагдсан бэлчээр (3км-ийн радиустай тойрог)=бог мал (нийт малын тоо) + бод мал(нийт малын тоо X 0.6)
2. Дээрхи 1-ээс бусад 3-5 км-ийн радиустай тойрог дотор=бод мал (нийт малын тооX0.4)
3. Тогтвортой усжуулагдсан бэлчээр (5 км-ийн радиустай тойрог) = бог мал (нийт малын тоо) + бод мал (нийт малын тоо)

1999, 2002 оны байдлаар тогтвортой усжуулалттай бэлчээрт ноогдож байсан малын тоо (бодит тоо ба хонин толгойд шилжүүлсэн), бэлчээрийн даац болон ашиглалтын балансыг 5.2.5 дугаар хүснэгтэд сум тус бүрээр нэгтгэн үзүүлэв.

Тогтвортой усжуулалттай 3 км ба 5 км-ийн радиустай тойргийн бэлчээрийн даацын ашиглалтын балансыг харьцуулан үзэхэд мал ихээхэн өссөн 1999 онд бэлчээр ашиглалтын баланс нь тус бүр 123.1%, 122.1% буюу онцын ялгаа ажиглагдахгүй байна. Гэвч 2002 оноос энэ үзүүлэлт 79.8% (3км), 66.3% (5 км) болж бэлчээр ашиглалтад ялгаа гарч эхэлсэн. Энэ нь 3 км-ийн радиустай тойрогт идээшлэх малын нягтрал өндөр, харин 3-5 км-ийн радиустай тойргийн хүрээнд идээшлэх малын нягтрал бага бөгөөд ерөнхийдөө мал худгийн ойр орчимд бөөгнөрөх хандлагатай байгааг харуулж байна.

Бэлчээрийн менежментэд анхаарвал зохих зүйлийн нэг бол гадна талын (3-5км-ийн радиустай тойргийн) бүсэд малаа идээшлүүлэхийн ач холбогдлыг ойлгож, энэ тойргийг малын бэлчээрт идэвхитэй ашиглах замаар мал маллагааны ур чадварыг дээшлүүлэх явдал юм. Мөн тухайн бэлчээрт идээшлэх бод малын тоог нэмэгдүүлэх зэргээр говийн нөхцөлд тохирсон малын тооны балансыг сайжруулах арга хэмжээ авах нь (3-5км-ийн радиустай тойргийн) хүрээг дээд зэргээр ашиглах үр дүнтэй арга зам байх болно.